ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ/

2018 оны 01 дүгээр сарын 15

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2017 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдлааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар гарсан шийдвэр заалтыг хяналтанд авч, эдгээрийн 2017 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, заалтыг 2017 оны 12 сарын 27-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын 6-р хавсралтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**.

2017 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 135 шийдвэрийн 188 заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт **90,6** хувийн биелэлттэй байна.

Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 7 шийдвэрийн 9 заалтын хэрэгжилт 100%, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 16 шийдвэрийн 21 заалтын хэрэгжилт 83,5%, Уул уурхайн бодлогын асуудлын 43 шийдвэрийн 58 заалтын хэрэгжилт 81,0%, Хүнд үйлдвэрийн бодлогын асуудлын 33 шийдвэрийн 43 заалтын хэрэгжилт 85,7%, Нийтлэг асуудлын 57 шийдвэрийн 95 заалтын хэрэгжилт 98,0%-ийн тус тус биелэлттэй байна.

Нийт 226 заалтын 41 заалт үнэлэх боломжгүй, хэрэгжилт гаргаж дүгнэсэн 185 заалтын 135 заалт буюу 73,0% бүрэн биелсэн, үлдсэн 50 заалт буюу 27,0% хэрэгжилтийн шатанд буюу 30-70 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН

ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

/2017 оны жилийн эцэс/

Хүснэгт-1

| | | | Бүгд | Монгол улсын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Ерөнхий сайдын захирамж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтанд авагдсан | | Шийдвэрийн тоо | 156 | 7 | 8 | 10 | 3 | 61 | 51 | 8 | 7 | 1 |
| | | Зүйл, заалтын тоо | 226 | 10 | 11 | 25 | 3 | 78 | 63 | 8 | 17 | 11 |
| Үүнээс | | Биелсэн 100% | 135 | 1 | 5 | 18 | 2 | 45 | 42 | 4 | 9 | 9 |
| | | ***Хэрэгжих шатанд*** | ***91*** | ***9*** | ***6*** | ***7*** | ***1*** | ***33*** | ***21*** | ***4*** | ***8*** | ***2*** |
| | Үүний дотор | 70.0% | 44 | 6 | 3 | 3 | - | 11 | 11 | 3 | 5 | 2 |
| | | 30.0% | 6 | - | - | - | - | 6 | - | - | - | - |
| | | Хэрэгжээгүй 0% | - | | | | | | | | | |
| | | Дүгнэгдээгүй | 41 | 3 | 3 | 4 | 1 | 16 | 10 | 1 | 3 | - |

Яамны эрхлэх асуудалд хамааралгүй, хэрэгжих хугацаа болоогүй, үндсэн хэрэгүүлэгч яамнаас санал ирээгүй 41 заалтууд байна.

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Газрын тосны тухай хуулийн 7.1.4.-т заасан, Газрын тосны бүртгэл, тооцооны журам, 8.1.3.-т заасан, Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага"-ыг боловсруулж батлуулах ажил сүүлийн 3 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт удаашралтай буюу 30-аас 70%-тай байна.
2. "Эрдэнэс монгол" ХХК болон түүний охин компаниудаас 2017 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээ тайлан ирүүлээгүй тул холбогдох шийдвэрийн биелэлтийг гаргуулж авахад бэрхшээлтэй байна. мөн Оюу толгой, Таван толгой, Цагаан суварга, Гацууртын ордын үйл ажиллагаатай холбогдон гарсан шийдвэрүүдийн биелэлт хангалтгүй гарч байна.
3. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх шийдвэрийн биелэлт гаргахад тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар толгойлон хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй байдал давтагдсаар байна. Үүнд ихэвчлэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага толгойлон хэрэгжүүлэхээр гарсан шийдвэрүүд хамаарч байна.
4. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажил, Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төсөлтэй холбогдсон шийдвэрүүдийн биелэлт удаашралтай байна.
5. Яамны холбогдох газруудаас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажил, хүрсэн үр дүнг тодорхой ирүүлэхгүй байна. Үүнээс шалтгаалж биелэлтийг дахин гаргуулж үнэлгээ хийхэд хугацаа алдах нөхцөл үүсч байна. Үнэлгээ хийх хугацаа алдагдсанаар тухайн шийдвэрийн биелэлтэд нотлох баримтанд үндэслэн дүгнэх боломж хязгаарлагдаж байна.
6. Яамны зүгээс тодорхой хийгдсэн ажлын биелэлтгүй, эрхлэх асуудалд хамааралгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, Засгийн газрын бүтэц

бүрэлдэхүүн өөрчлөгдсөн шалтгаанаар үргэлжлэн хэрэгжээгүй, дээд шатны байгууллагаас ажлыг зогсоосон зэрэг 41 заалтад үнэлгээ өгөөгүй болно.

**Тав. Зөвлөмж**.

1. Хяналтанд авагдсан шийдвэр, заалтыг хариуцах нэгж, албан хаагчийг тодорхой болгож ...
2. Уул уурхайн бодлоготой хамаарах шийдвэр заалтын хэрэгжилтийг сайжруулах, холбогдох аж ахуйн нэгжүүдээс мэдээллийг гаргуулж ирүүлэхэд ажил хариуцсан нэгж анхаарч ажиллах,
3. “Эрдэнэс монгол” ХХК болон түүний охин компаниудаас 2017 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээ тайлан ирүүлээгүй, холбогдох захирал удирдлагад хариуцлага тооцох.
4. Бодлогын газрууд биелэлтийг тогтоосон хугацаанд чанартай гаргаж ирүүлэх, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнаж хэвших,
5. Хууль тогтоомжийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан ... шийдвэрийн, .... заалтыг хяналтаас хасуулах саналыг ХЭГ-т хүргүүлэх,
6. Цаашид холбогдох нэгжүүдийн мэргэжилтнүүд баримт бичиг боловсруулах ур чадвараа сайжруулж, ирүүлж буй тайлангийн чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар сайтар хянаж, арга зүйн дэмжлэг үзүүлэх, ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН АКТЫН БИЕЛЭЛТ

(2017 оны жилийн эцэс)

| Дугаар Ш | Дугаар Зз | Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт | ХБ, ХБЗ ХТТ АХ | Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|
| | | **НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО** | | | |
| | | **1.а. Монгол Улсын хууль** | | | |
| 1 | 1 | **ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ** 2014-01-09<br>3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно. | ГБГ | Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдөр 222 дугаар тогтоолоор Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг хавсралт ёсоор баталсан. **ХААХ САНАЛТАЙ** | 100 |
| | | **1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | |
| 1 | 1 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2015-04-22<br><br>1 Монгол Улсын Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2011 оны 175 дугаар тогтоол Газрын тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцэхгүй байх тул хуульд нийцүүлэн өөрчлөх, эсхүл хүчингүй болгохыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай. | ГБГ | Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолыг Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.7 дэх хэсэгтэй нийцүүлсэн. Тогтоолын заалт 100 % хэрэгжсэн. **ХААХ САНАЛТАЙ** | 100 |
| | 2 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2015-04-22<br><br>2 2.Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Уул уурхайн яам /Р.Жигжид/-нд даалгасугай | ГБГ | Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан. Тогтоолын заалт 100 % биелсэн. **ХААХ САНАЛТАЙ** | 100 |
| | | **1.д. Засгийн газрын тогтоол** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | Талбайн солбицол тогтоох тухай 2017-01-25<br><br>2 ”Алт-2” үндэсний хөтөлбөртэй уялдуулан алтны нөөцийг өсгөж олборлолтыг дэмжих, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн хэрэгжүүлэх зорилгоор алтны хэтийн төлөв бүхий нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | ГБГ | Хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 37, 234 дүгээр тогтоол батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг Заамарын болон Сэлэнгийн нутаг дэвсгэрийн хүрээнд хийж хил заагийг тогтоон Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн боловч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санал ирүүлээгүй учир хойшлогдсон. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт орсонтой уялдан эрх зүйн үндэслэлгүй болсон. **<u>ХААХ САНАЛТАЙ</u>** | 100 |
| | 2 | Талбайн солбицол тогтоох тухай 2017-01-25<br>3 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлэн ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт үүрэг болгосугай. | ГБГ | Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 239, 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 511, 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолуудаар сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоож нийтэд мэдээлж, нийтэд мэдээлсэн талбайн хүрээнд зохих журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж байна. Сонгон шалгаруулалтын төлбөрөөр улсын төсөвт 2017 оны жилийн эцсийн байдлаар 12 багцаар 33 тусгай зөвшөөрөл олгосон ба улсын төсөвт 15,8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. | 100 |
| 2 | 3 | **Байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай**<br>2017-03-15<br><br>2 Хилийн заагийг баталсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид, мэдээллийн санд бүртгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт, хамгаалалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт тус тус үүрэг болгосугай. | ГБГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/110 дугаар тушаалаар нөхөн олговорын хэмжээ тогтоох Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн ажлын хэсэг ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 90, 91 дүгээр тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу ажлын хэсэгт ажиллаж, холбогдох хуулийн дагуу давхцалтай хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийг цуцлаж, талбайг дүйцүүлэн олгох тухай Засгийн газрын 256 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг тогтоолын дагуу 9 тусгай зөвшөөрлийг цуцлаж, 18 тусгай зөвшөөрөл шинээр олгосон. **<u>ХААХ САНАЛТАЙ</u>** | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 4 | **Талбайн солбицлыг тогтоон нийтэд мэдээлэх тухай 2017-03-29 №: 2017_106**<br><br>2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлж, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэн тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай. | ГБГ | АМГТГ-ын даргын 2017 оны а/130 дугаар тушаалын 2.4 дэх хэсэгт заасны дагуу АМГТГ-ын даргын 2017 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн а/145 дугаар тушаалаар хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийн цахим дугаар олгох үйл ажиллагааг 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 9 цаг 00 минутаас зохион байгуулахаар шийдвэрлэнсэн. Уг шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох үйл ажиллагаа явагдсан боловч техникийн саатлын улмаас, тодруулбал, Үндэсний дата төв дээр байрших серверт доголдол үүссэнээс шалтгаалж саатсан. Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг бүхэлд нь хүчингүй болгон тусгай зөвшөөрлийг сонгон шаларуулалтын журмаар олгохоор болсон тул өргөдлийн дугаарыг цахим системээр олгох үйл ажиллагааг дахин явуулах боломжгүй болсон. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 4 | 5 | Нөхөх олговрын зориулалтаар олгох тусгай зөвшөөрлийн талбайн солбицол батлах тухай<br>2017-09-13 №: 2017_256<br><br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу нөхөх олговор олгож байгаатай холбогдуулан тусгай зөвшөөрөл шинээр олгох болон тусгай хамгаалалттай газарт талбай нь давхацсан аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогтод, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдоржид тус тус даалгасугай. | ГБГ | Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хилийн заагтай давхцалтай 9 тусгай зөвшөөрлүүдийг цуцалж, нөхөх олговрын зориулалтаар 18 тусгай зөвшөөрлүүдийг шинээр олгосон. /Хэрэгжилт-100%/<br>**ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл**<br>2014-10-04<br><br>XYI. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | ГБГ | Монгол Улсын Геологийн салбарын бодлого, хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулан шинэчлэн гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/113 тоот тушаалаар байгуулан тандан судалгааны ажил хийгдэж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдэлийн судалгаа хийсэн тайланг хүлээн авч судлан үзсэний үндсэн дээр ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна. | 100 |
| **ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО** | | | | | |
| **2.а. МУ-ын хууль** | | | | | |
| 1 | 1 | **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/**<br>2014-07-01<br>7.1.4 нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; газрын тосны салбарыг хөгжүүлэх сан; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах; | ТБГ | 1. Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төслийг боловсруулж, бүх яамдаас саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 25-ны 01/2723 дугаар албан тоотоор хүргүүлж, 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>Газрын тосны бүртгэл, тооцооны журмын төслийг боловсруулж, дотоодын зөвлөхийг ажиллуулсан. Боловсруулсан төсөл дээр АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс саналыг авч тусган АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран семинар зохион байгуулсан. Журамтай холбогдуулан 2 удаа АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц зохион байгуулсан. Тус журмын төслийг бэлтгэж байна.<br>2. Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг боловсруулж, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагуудаас санал авч тусган, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн 2015 оны 5-р сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Журмын төсөлд яамдаас санал авч холбогдох саналыг тусган Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 295 дугаар тогтоолоор батлуулсан. Уг журмыг Уул уурхайн /хуучин нэрээр/ яамны цахим хуудсанд www.mm.gov.mn байршуулсан.<br>3. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2014.01.23-ны өдрийн хуулиар "Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан"-г хассан. Иймд тус журмыг боловсруулах шаардлагагүй болсон. | 70 |
| | 2 | **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/**<br>2014-07-01 | ТБГ | 1. Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч хянан тусгасан. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8.1.3 газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах; | | 2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлагыг эцэслэн боловсруулж, мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.03.10-ны 49 тоот тушаалаар батлуулсан. Мөн Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд журмын дагуу бүртгүүлж, Уул уурхайн /хуучин нэрээр/ яамны цахим хуудсанд www.mm.gov.mn байршуулсан. | |
| | | | | 3. Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлагыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч төсөлд тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 197 дугаар тушаалаар батлуулсан боловч Захирагааны ерөнхий хуульд батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийн Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаал гаргуулахад бэлэн болсон. | |
| | | | | 4. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмыг боловсруулж, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны 202 тоот тушаалаар батлуулан Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд 2014.10.15-ны өдөр нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын жагсаалтад бүртгүүлсэн. | |
| | | | | 5. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлуулсан боловч боловч Захирагааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийн Захиргааны хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаал гаргуулахад бэлэн болсон. | |
| | | | | 6. Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмын төслийг боловсруулж, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаар тушаалаар батлуулсан. Уг журмыг ХЗЯ-аар /хуучин нэрээр/ бүртгүүлж, УУЯ-ны /хуучин нэрээр/ www.mm.gov.mn цахим хуудсанд байршуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3 | **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/** 2014-07-01 8.1.8 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; | ТБГ | “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг боловсруулах БОНХАЖ /хуучин нэрээр/, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.03.24-ний өдрийн 62/А-131 дугаар хамтарсан тушаалаар байгуулж, төслийг боловсруулан БОНХАЖ-ийн /хуучин нэрээр/ сайдын зөвлөл, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. УУС-ын /хуучин нэрээр/ тушаалаар батлуулж, журмын дагуу Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд бүртгүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлж хүргүүлсэн болович Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийн Захиргааны хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаал гаргуулахад бэлэн болсон. | 70 |
| | 4 | **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/** 2014-07-01 8.1.9 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | ТБГ | “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-г боловсруулж, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдээс саналыг авсан. Дүрмийн төслийг Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамны удирдлагуудад журмыг батлах тухай тушаалын төслийг хамт танилцуулан санал авч тусгасан. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу дүрмийн төслийг яамны цахим хуудсанд байршуулж. төрийн болон төрийн бус байгууллага. иргэд аж ахуй нэгжүүдээс саналыг авч байна. | 70 |
| **2.б. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан** 2016-11-17 №69 2/2. түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. | ТБГ | Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төслийг боловсруулж, бүх яамдаас саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 25-ны 01/2723 дугаар албан тоотоор хүргүүлсэн. 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>МУ-ын ЗГ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан. Уг гэрээний 15 дугаар зүйлийн 15.2-т " гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгана." гэж заасан. Ашиглалтын талбайн тухайд гэрээлэгч компиудтай хэлэлцээр хийгдэж байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл** | | | | | |
| 1 | 1 | **Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай** 2014-10-20 №2014_52/30 2.5 Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх | ТБГ | Багануурын нүүрсний уурхайг түшиглэн жилд 725 сая.м3 нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Шинжлэх Ухаан Техникийн Зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцэн хүлээж авсан. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төслийн байгаль орчны үнэлгээний ажлыг Green Trend ХХК гүйцэтгэж байна. Хөрөнгө оруулалтын чиглэлээр гадны хөрөнгө оруулагчидтай уулзалт, хэлэлцээр хийсэн ба хөрөнгө оруулагчид хамтран ажиллах хувилбар, саналаа илэрхийлээд байна. Нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр “Хайланд Петролеум” ХХК, "Петровис ресурс" ХХК, Эрдэнэс метан ХКомпаниудтай эрлийн гэрээ байгуулан ажиллаж байна.Австрали улсын “Голден Хорд Лимитэд” компанитай Газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажлыг гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах хэлэлцээр хийж, гэрээний үндсэн нөхцлүүдийг тохиролцсон. Уг гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотойгоор яамдаас санал авах албан тоотуудыг 2018 оны 01 дүгээр сарын 02-нд явуулаад байна. Монгол Улс нүүрсний давхаргын метан хийн ихээхэн (17-43 триллион шоо метр) нөөцтэй байж болох тухай зарим судлаачид судалсан байдаг. Эрдэнэс Монгол компанийн захиалгаар БНСУ-ын Когаз, Австралийн Голден Хорд болон Нордик Гео Солюшн, Элгэн зэрэг компаниудын хийсэн судалгааны тайланд Таван Толгойн ордын нүүрсний давхаргын метан хийн нөөцийг урьдчилсан төсөөллөөр /40 сая.тн буюу 4.7 тэрбум метр куб/ тогтоосон байна. | 100 |
| **2.е. ЗГ-ын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох тухай** 2015-11-02 №431 2 Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлан газрын тосны тухай хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай. | ТБГ | Газрын тосны хайгуулын Тариач-XV талбайд Газрын тосны газар /хуучин нэрээр/, “Чайна Голден Сий Петролеум Эксплорейшн Корпорейшн” ХХК-ийн хооронд байгуулсан БХГ-г цуцалж, талбайг буцаан авахтай холбогдон гэрээлэгч компани шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотойгоор гэрээг цуцлах арга хэмжээ авагдаагүй байна. Шүүхээс гэрээлэгчийн БХГ-г нэг талын саналаар гэрээг цуцлах боломжгүй шийдвэр гарсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг дүгнэх нь зүйтэй гэж үзсэн ба АМГТГ болон гэрээлэгч компани гэрээний хэрэгжилтийг гарган ажиллаж байгаа болно. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | **Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**<br>2016-11-16 №147<br>2 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81 900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх ажлыг 2017 оны 3 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | ТБГ | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг АМГТГ нь 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компанийн нөөц бүрдүүлэх, түүнд хяналт тавих талаар аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 38 хоног /105491.09 тонн/-ийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 68 /16394.29 тн/, Аи-92 болон Аи-95 автобензин 47 /45463.8 тонн/, дизелийн түлш 28 /41460.9 тонн/, ТС-1 онгоцны түлш 24 хоног /2172.1 тн/-ийн нөөцтэй байна. | 100 |
| 3 | 3 | **Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**<br>**2017-01-25 №34**<br>2 Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний хангамж, нийлүүлэлт, жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нарт үүрэг болгосугай. | ТБГ | Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор татварын зохицуулалт хийж, импортын автобензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварын хэмжээг төвийн бүсэд 30,000-70,000 төгрөгөөр, зүүн бүсэд Эрээцав боомтоор орж ирэх шатахууны онцгой албан татварын хэмжээг төрөл тус бүр дээр тэглэж /0/ тус тус тогтоон, дотоодод борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнийн өсөлтийг саармагжуулах талаар арга хэмжээ авсан.<br>Шуурхай арга хэмжээг тухай бүр авч, онцгой албан татварын хэмжээг бүс нутгаар нь ялгавартай тогтоосноор алслагдсан бүс нутгаг болон төвийн бүсийн шатахууны үнийн зөрүү 20-60 төгрөг байна. Монгол Улсын хэмжээнд борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнэ 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Баруун бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1736 төгрөг, ДТ 1806 төгрөг, Зүүн бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1707 төгрөг, ДТ 1827 төгрөг, Төвийн бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1713 төгрөг, ДТ 1768 төгрөг байна. Мөн Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолын дагуу газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх ажлын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажилласан. Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн **207** дугаар тогтоолоор Засгийн газрын 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. | 100 |
| 4 | 4 | **Хөтөлбөр батлах тухай**<br>**2017-03-20 №98** | ТБГ | Багануурын нүүрсний уурхайг түшиглэн жилд 725 сая.м3 нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Шинжлэх | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.<br>Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан тус яамны хариуцан хэрэгжүүлэх заалтууд: 4.2.12. “Нүүрсний давхаргын метан хийн нөөцийн судалгааг эрчимжүүлж, нүүрс баяжуулах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах үйл ажиллагааг дэмжих”, 4.3.2. “Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах” | | Ухаан Техникийн Зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцэн хүлээж авсан.“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төслийн байгаль орчны үнэлгээний ажлыг Green Trend ХХК гүйцэтгэж байна. • Хөрөнгө оруулалтын чиглэлээр гадны хөрөнгө оруулагчидтай уулзалт, хэлэлцээр хийсэн ба хөрөнгө оруулагчид хамтран ажиллах хувилбар, саналаа илэрхийлээд байна.Евро 5 стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортлох, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, онцгой албан татварын хэмжээг чанар стандарттай уялдуулан тогтоох хууль эрхзүйн орчин бүрдүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох бичиг баримтыг боловсруулж Сангийн яаманд 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/2756 албан бичгээр хүргүүлсэн.Ашигт малтмал, газрын тосны газрын лабораторийн үйл ажиллагааг жигдрүүлэх, эрчимжүүлэх ажлын хүрээнд АМГТГ болон БНСУ-ын Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамжийн газар /К-Петро/ хооронд “Техникийн Хамтын Ажиллагааны САНАМЖ БИЧИГ”-ийг байгуулан сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллаж байна. Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр ГЕГ, МХЕГ, АМГТГ, ШӨХТГ зэрэг төрийн байгууллагуудыг оролцуулсан “Шатахууны чанар, стандартын хяналтын тогтолцоог сайжруулах” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Евро-5 стандартын шатахууныг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотойгоор борлуулалтын үнийн асуудлыг ард иргэдэд санхүүгийн хүндрэл багатайгаар оновчтой шийдвэрлэх боломжийн талаарх асуудлыг “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн зургадугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас гаргасан 06 дугаар Зөвлөмжийн 5 дугаар заалтаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Евро-5 стандартын чанарын шаардлага хангасан шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх, үнийг ялгавартай тогтоох, цаашид автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газар болон шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж болгосон. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанд тус хорооны гишүүн УУХҮ-ийн дэд сайд Д. Загджав “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УУХҮЯ-наас хийж гүйцэтгэсэн ажил, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх танилцуулгыг хийсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 5 | **Төв, суурин газрын 2017 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай** 2017-06-28 №2017_187 8. Газрын тосны бүтээгдэхүүний 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, намрын ургац хураалт, уринш боловсруулалтын үед шатахуунаар тасралтгүй хангах ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгасугай. | ТБГ | Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний 2017 оны компанийн нөөцийг 81900 тонн буюу 30 хоногийн хэрэглээнээс доошгүй байхаар тогтоосон. 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 38 хоног /105491.09 тонн/-ийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 68 /16394.29 тн/, Аи-92 болон Аи-95 автобензин 47 /45463.8 тонн/, дизелийн түлш 28 /41460.9 тонн/, ТС-1 онгоцны түлш 24 хоног /2172.1 тн/-ийн нөөцтэй байгаа нь тогтоолын хэрэгжилтийг хангаж байна. 2017 онд дунджаар 47 хоногийн нөөцтэй байсан болно. | 100 |
| | 6 | 9. 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийн жагсаалт, нөөц бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг 2017 оны 9 дүгээр сард багтаан батлуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | ТБГ | Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 297 дугаар тогтоолоор 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг тогтоож батлуулсан. | 100 |
| 6 | 7 | **Тогтоолд өөрчлөлт оруулах тухай** 2017-07-18 №207 2. Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний хангамж, нийлүүлэлт, жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, | ТБГ | Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын сантай хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь хэмжээг 2017 оны 07, 10 дугаар саруудад үе шаттайгаар сэргээхээр тохиролцсон. Үүний дагуу уг тогтоолоор автобензин, дизель түлшний онцгой албан татварыг сэргээсэн хэдий ч тухайн сарын шатахууны импортын үнэ буурсан, төгрөгийн ханш ам.долларын эсрэг чангарсан зэрэг зах зээлийн таатай нөхцөл бүрэлдсэнээр импортлогч компаниуд татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар өнөөг хүртэл жижиглэн үнийг тогтвортой хадгалж ирсэн. Монгол Улсын хэмжээнд борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнэ 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Баруун бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1716 төгрөг, ДТ 1812 төгрөг, Зүүн бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1717 төгрөг, ДТ 1827 төгрөг, Төвийн бүсийн дундаж үнэ литр тутамд Аи-92 автобензин 1703 төгрөг, ДТ 1761 төгрөг байгаа нь тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж байна. Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор 2017 оны 207 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нарт үүрэг болгосугай. | | | |
| 7 | 8 | **Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** 2017-10-03 №297<br><br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт даалгасугай. | ТБГ | Засгийн газрын тогтоолын хавсралтад дурьдсан 21 аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах тухай үүрэг, чиглэлийг АМГТГ-т 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 03/2321 тоот албан бичгээр хүргүүлсэн. АМГТГ нь тус аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахаар ажиллаж байгаа болно. | 70 |
| | 9 | 3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэж улсын нөөцөд 94 700 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний газрын тосны бүтээгдэхүүн бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдорж нарт даалгасугай. | ТБГ | Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэх талаар холбогдох саналаа СЯ-нд 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 01/2348 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Өнөөдрийн байдлаар ямар нэгэн хариу ирүүлээгүй байна. | /-/ |
| 8 | 10 | **Тогтоолд өөрчлөлт оруулах тухай** | ТБГ | Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын сантай хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Автобензин, дизелийн түлшний онцгой албан | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2017-11-15 №:309**<br><br>2. Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний хангамж, нийлүүлэлт, жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нарт үүрэг болгосугай. | | татварын хувь хэмжээг үе шаттайгаар сэргээхээр тохиролцсоны дагуу Засгийн газрын 2017 оны 309 дүгээр тогтоолоор автобензин, дизель түлшний онцгой албан татварыг нэмэгдүүлсэн. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2017 оны 07 дугаар сараас тогтмол өсөлттэй байсан, автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээ нэмэгдсэн хэдий ч АМГТГ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдэд нөөц болон татан авалтаа нэмэгдүүлэх, бусад боломжит нөөц бололцоог ашигланшатахууны үнийг тогтвортой байлгах чиглэлийг өгсний дагуу шатахууны жижиглэн борлуулалтын үнийг тогтвортой хадгалж ирсэн.<br>Монгол Улсын хэмжээнд 2018 оны 01 дүгээр сарын 02-ны байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 40 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 71, Аи-92 автобензин 41, дизелийн түлш 35, ТС-1 онгоцны түлш 26 хоногийн нөөцтэй байна. Улаанбаатар хотод А-80 автобензиныг 1470₮, Аи-92 автобензиныг 1630₮, Дизель түлшийг 1720₮-өөр борлуулж байна. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөн, Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан, автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг үе шаттайгаар нэмэгдсэн зэргээс хамааран шатахууны жижиглэн борлуулалтын үнэ нэмэгдэх нөхцөл үүсээд байгаа талаар Монголын газрын тосны бүтээгдэхүүний импортлогчдын мэргэжлийн холбоод болон импортлогч компаниудаас удаа дараа мэдэгдсэн. Иймд шатахууны жижиглэн борлуулалтын үнэд өөрчлөлт орох нөхцөл бүрдсэн талаарх тулгамдаж буй асуудлыг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. | |
| **2.ж. ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 1 | 1 | **2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тэмдэглэлд**<br>2013-07-06<br>2 XIII. 2. "Газрын тосны олборлолт, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайгаас Монгол, Хятадын хилийн Баянхошуу боомтын чиглэлд 210,7 км хатуу хучилттай авто зам барих ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож ажиллахыг Зам тээврийн сайд | ТБГ | Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210,7 км хатуу хучилттай авто замын 105 км хийгдэж дуусаад, улсын комисс хүлээж авсан. Үлдсэн 3, 4 дүгээр хэсгийн барилгын ажил эрчимтэй явагдаж байна. Уг ажлыг гүйцэтгэж буй “Арж Капитал” ХХК нийт 300 гаруй ажилчид, 195 техник хэрэгслээр 4 дүгээр хэсгийн 54 км авто замын барилгын ажлыг бүрэн дуусгасан ба 12 дугаар сард багтаан Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Харин 3 дугаар хэсгийн 54 км авто замын барилгын ажлын гүйцэтгэл 60 хувьтай явж байгаа ба тус замыг 2018 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна. Авто замын барилгын ажлын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт буцах нөхцөлтэйгээр оруулж ирэх 369,460 ам.долларын зөөврийн чулуу бутлуур, буцахгүй нөхцөлтэйгээр оруулж ирэх 464,000 ам.долларын үнэ бүхий тоног, төхөөрөмж, бараа материалыг холбогдох татваруудаас чөлөөлүүлэх хүсэлтийг судалж, боломжтой гэж үзэн ГЕГ-т дэмжлэг хүссэн 1/2762 албан тоот хүргүүлж, гэрээлэгчид дэмжлэг үзүүлсэн. Тус замын барилгын ажлын хөрөнгө оруулагч болох Петрочайна Дачин Тамсаг ХХК нь ажлын гүйцэтгэлийг тусгай хяналтын компаниар хянуулж байгаа УУХҮЯ болон АМГТГ-ын зүгээс хяналтын компанийг талбай дээр ажиллуулах тал дээр арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлж ажиллаж байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт тус тус даалгав. | | | |
| 2 | 2 | **2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 12 дугаар тэмдэглэл** 2016-02-29 XҮ. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх явцад үүссэн зарчмын зөрүүтэй асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд үүрэг болгов. | ТБГ | Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/57 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Тушаал батлагдснаас хойш 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 10 гэрээлэгч аж ахуйн нэгжтэй уулзалт хэлэлцээр хийж “Импайр газ Монголиа” ХХК, “Монголын Алт” ХХК, “Вульф петролиум” ХХК, “Эн Пи Ай” ХХК зэрэг аж ахуйн нэгжийн шинэчилсэн БХГ-г баталгаажуулав.<br>- Онги-IV, Богд-V талбайд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК<br>- Нялга XVI талайд “Шэйман” ХХК-ийн БХГ-г шинэчлэн баталгаажуулахад бэлэн болгоод байна.<br>Хайгуул, ашиглалтын шатны БХГ-нүүдийг шинэчилсэний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | 70 |
| 3 | 3 | **2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 15 дугаар тэмдэглэл** 2016-03-14 IҮ. Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарын санаачлан боловсруулсан Шатахууны эрсдэлийн нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хууль санаачлагчтай тохиролцсоны үндсэн дээр хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулах ажлыг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | ТБГ | УУХҮ-ийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг батлуулсан. Шатахууны эрсдлийн нөөцтэй холбоотой асуудлыг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган шийдвэрлэх боломжтой тул тус хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй болсон. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 4 | **2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл** 2017-03-29<br><br>2 Нисэх онгоцны шинэ буудлыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав. | ТБГ | Замын Үүд боомтод агаарын хөлгийн шатахууныг импортлох асуудлаар 2017 оны 02, 03 дугаар саруудад Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж /ШТШАБ/ ТӨҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын уулзалтуудыг хийсэн. ИНЕГ, Замын-Үүд дэх ийн ШТШАБ-ын удирдлагуудтай хийсэн холбогдох уулзалтын хурлын шийдвэрийн дагуу АМГТГ, ИНЕГ-ын даргын 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/265, а/59 дугаар хамтарсан тушаалаар ШТШАБ-ын өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах, хяналт тавих, батлуулах, хүлээн авах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулагдсан.<br>Ажлын хэсэг зургийн даалгавар боловсруулахтай холбогдуулан Замын-Үүд суманд 2017 оны 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажилласан бөгөөд ШТШАБ-ийг өргөтгөхтэй холбоотойгоор газрын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай талаар дүгнэлтийг гарган, шийдвэрлүүлэхээр хүсэлтийг тус аймгийн Засаг даргад хүргүүлсэн. Үүний үр дүнд байгууламжийн өргөтгөлд шаардлагатай газрын хэмжээг нэмэгдүүлэх асуудал Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэж, тус хурлын 2017 оны 17 тоот тогтоолоор батлагдан, Дорноговь аймаг, Замын Үүд сумын Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/163 дугаар захирамжаар “ЗҮ-ШТШАБ” ТӨҮГ-т 1 га газрыг 15 жилийн хугацаатай шинээр нэмж олгох шийдвэрийг гаргуулсан. Түүнчлэн Ажлын хэсэг нэмж шинээр өргөтгөх хэсгийн сав, насос станц, технологийн шугам хоолой барих газрыг урьдчилсан байдлаар төлөвлөн, зургийн даалгавар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн батлуулав. | 70 |
| 5 | 5 | **2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл** 2017-10-20<br><br>6. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2018 оны 1 дүгээр сард багтаан бүрдүүлэх арга хэмжээ авч, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангаи нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | ТБГ | Засгийн газрын 2017 оны 297 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын 2018 оны нөөцийг 94700 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоосон. Уг ажлын хүрээнд холбогдох чиглэлийг АМГТГ-т 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 03/2321 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг чиглэлийн дагуу компанийн нөөц бүрдүүлэх үүрэг бүхий 21 аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахаар холбогдох арга хэмжээг АМГТГ авч ажиллаж байгаа болно. | 70 |
| **ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3.а. МУ-ын хууль** | | | | | |
| 1 | 1 | **Цөмийн энергийн тухай**<br>**2009-07-16**<br>33.4 Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална. | УУБГ | Тус асуудлыг чиг үүргийн дагуу Цөмийн энергийн комиссын Ажлын алба хариуцан ажилладаг. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 2 | 2 | **Хүний хөгжил сангийн тухай**<br>**2009-11-18 №: 2009_03**<br>13.2 Энэ хуулийн 13.1-д заасан сонгон шалгаруулалтын журам болонменежментийн гэрээг Засгийн газар батална./13.1.Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн чиг үүргийг дараахь шаардлагыг хангасан олон улсын санхүүгийн байгууллагад сонгон шалгаруулалтын үндсэн дээр менежментийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно: 8.2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ./ | УУБГ | "Хүний хөгжил сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай" хуулийг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аас баталсан бөгөөд тус хуулийн 1 дүгээр зүйлд 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай гэж тус тус заасан байна. Тус хууль хүчингүйд тооцогдсон тул 2017 оны биелэлт гаргах шаардлагагүй. /Хасах саналтай/ | /-/ |
| 3 | 3 | **ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)**<br>2013-01-31<br>10.1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална. | УУБГ | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмын төслийг боловсруулж байна. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд Ажлын хэсгийг 7 хоног бүр хуралдуулан журмын төслийг 2018 оны 1 дүгээр сард багтаан батлуулахаар ажиллаж байна.<br>/Биелэлт-70%/ | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 4 | **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ** 2015-02-18<br><br>47.2 Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална. | УУБГ | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголия" ХХК-иас Гацууртын ордын нөөц болон Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг батлуулах шаардлагатай байгаа тул уг асуудал хүлээгдэж байна.<br>/Биелэлт 90%/ | 70 |
| **3.б. Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай** 2010-07-07<br>1.2.а Монгол Улсын нийт иргэнд эхний ээлжинд хувьцааны 10 хувийг адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх; | УУБГ ЭТТ | УИХ, Засгийн газрын шийдвэрээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 20 хүртэлх хувийг буюу иргэн бүрт 1072 ширхэг хувьцааг 1.0 сая төгрөгөөр тооцон эзэмшүүлж, 1.0 сая төгрөгийн хишиг, хувь бэлэн мөнгөөр авсан /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, их, дээд сургуулийн оюутнууд-сургалтын төлбөр хэлбэрээр/ иргэдээс хувьцааг буцааж төрийн эзэмшилд бүртгэсэн. Иргэд эзэмшиж буй 1072 ширхэг хувьцаагаа нэрлэсэн үнээр нь зөвхөн Засгийн газарт худалдаж болохоор УИХ, ЗГ-ын тогтоолд заасан ба 1.5 орчим сая иргэд хувьцаагаа Засгийн газарт зарж 1.0 сая төгрөгөө бэлнээр авах хүсэлт гаргасан. Тухайн үед “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг аж ахуй нэгжид худалдсаны орлогоор Засгийн газарт хувьцаагаа худалдах хүсэлт гаргасан иргэдийн хувьцааг худалдаж авахаар тооцсон боловч хангалттай орлого төвлөрөөгүй. Улмаар хувьцаагаа худалдаж 1.0 сая төгрөг авах хүсэлт гаргасан иргэдийн хувьцааны төлбөрийг олгоогүй боловч Засгийн газрын дансанд бүртгэсэн байсныг Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоолоор буцаан иргэдийн нэр дээр бүртгэсэн. Засгийн газрын 2017 оны 154 дугаар "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, "Эрдэнэс Тавантолгой" ХК зэрэг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж санал дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн саналын дагуу Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 2,511,332 иргэн 2,212,223,863 ширхэг хувьцаа буюу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 14.55 хувийг эзэмшиж байна. /Биелэлт-100%/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2 | **Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай** 2010-07-07<br><br>1.2.б б/хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах; | УУБГ ЭТТ | 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуй нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуй нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалсаны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн. Засгийн газрын 2017 оны 154 дугаар "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшийгчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна.<br>/Биелэлт-90%/ | 70 |
| | 3 | **Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай** 2010-07-07<br><br>1.2.в хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах; | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон.<br>Харин Засгийн газрын 2016 оны 316 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд дээрх хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн.<br>/Биелэлт 30%/ | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 4 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан**<br>2016-11-17<br><br>1.2.1 Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:<br>1.коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй нийцүүлэх, нэгдсэн нэг үнээр экспортод гаргах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | УУБГ | Эрдэс баялгийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах уялдаа холбоо бүхий “нэг цонхны бодлоготой” болох зорилтын хүрээнд "Эрдэс баялгийн бирж байгуулах тухай" Засгийн газрын 2014 оны 211 дүгээр тогтоолын дагуу Эрдэс баялгийн биржийн эрхзүйн орчныг бүрдүүлэхээр Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж Засгийн газрын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Уул уурхайн сайд, Хууль зүйн сайдад даалгасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу хуулийн төслийг боловсруулж Уул уурхайн сайдын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1/297 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлж амжилгүй бүрэн эрхийн хугацаа дууссан.<br>Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дугаар тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн баримт бичигт Эрдэс баялгийн түүхий эдийн биржийг байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох "Эрдэс баялгийн биржийн тухай хууль"-ийг хариуцан боловсруулах байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам байхаар тусгасан байна. **ХЯНАЛТААС ХАСУУЛАХ** | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2013-02-07<br><br>1.11 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн барилга, уул уурхай, эрчим хүч, зам, тээвэр, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажил олгогч, ажилтанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулдаг болох, үүнтэй холбогдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах; | УУБГ | Хөдөлмөр, нийгмийн 3 талт үндэсний хорооны салбар нэгж болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн А/48 тоот тушаалаар байгуулан салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлогыг томъёолох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн ХНХЯ болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж, Уул уурхайн салбарын аж ахуй нэгж, ажилчдад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, ажил хийгдэж байна. Тухайлбал салбар хорооноос НЭН ТҮРҮҮНД ХАБ-2017 үндэсний бага хурлыг зохион байгуулах удирдах хороонд ажиллаж, 2017 оны 3-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулж, Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангаж ажилласан.<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2018 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ХАБЭА-н дэд хөтөлбөр боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Тус дэд хөтөлбөрт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх талаар тусгахаар ажиллаж байна.<br>/Биелэлт-100%/ | 100 |
| **3.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2011-01-19<br>II.1.1 МУ-ын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолын 3 дахь заалтын биелэлтийг хангах, АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай<br>Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийж шийдвэрлэх | УУБГ | 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн Газар (Эрдэнэс Оюу Толгой ХХК) болон Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон Оюу Толгой ХХК-ийн хооронд Оюу толгой төслийн 2 дахь шат буюу Далд Уурхайн Бүтээн байгуулалтын,санхүүжилтийн гэрээг байгуулсан. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил хэвийн явагдаж байна. /ХЯНАЛТААС ХАСУУЛАХ/ | 70 |
| 2 | 2 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015-02-18**<br>1.3. Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтааж танилцуулах | | Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын хүрээнд Уул уурхайн салбарын 2025 он хүртэлх гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг төлөвлөж 2015 оны 6 дугаар сард Сангийн яаманд хүргүүлсэн.<br>/Биелэлт-100%/ | 100 |
| 3 | 3 | **Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай**<br>2015-04-08 №10<br>1.1 УИХ-ын 2010 оны 39, 2012 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах шуурхай арга хэмжээ авч, "Эрдэнэс тавантолгой" хувьцаат компаний хувьцааны эзэмшилийн бүртгэлийг баталгаажуулах ажлыг 2015 онд багтаан хэрэгжүүлэх | УУБГ | Тогтоолын дагуу эзэмшлийн бүртгэлийг баталгаажуулах зорилгоор Засгийн газрын ХЭГ, Сангийн яам, Уул уурхайн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Эрдэнэс Монгол” ХХК, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Улсын бүртгэлийн ерөнхий газар”, “Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар”, “Нийгмийн даатгалын ерөнхий газар”, ЭТТ ХК-ийн төлөөлөл оролцсон ажлын хэсгийг байгуулж ажилласан боловч нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй. Иймд Засгийн газрын ХЭГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 283 дугаар тушаалаар 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж "Эрдэнэс тавантолгой"ХК-ийн хувьцааны эзэмшилийн бүртгэлийг бүрэн хийж дуусгаад байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4 | 1.5 Засгийн газарт болон "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс монгол" ХХК-д Эдийн Засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | | УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Тавантолгойн Цанхийн Зүүн уурхайн гэрээт олборлолтын ажлын хөлс болон нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлж барагдуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот /2015.04.28-ны 1/1004/-ыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүргүүлсэн. Биелэлт-100% **/Хяналтаас хасуулах/** | 100 |
| 4 | 5 | **Чиглэл өгөх тухай**<br>2015-05-29<br><br>3 Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах | УУБГ | "Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж Уул уурхай сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 229/А/232 дугаар хамтарсан тушаалаар батлуулж мөрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр Оюу толгойн дал уурхайн бүтээн байгуулалтын ажлыг олон улсын стандарт шаардлагад нийцсэн дүрмийн дагуу явуулах боломж бүрдсэн. /Биелэлт-100%/ **ХЯНАЛТААС ХАСУУЛАХ** | 70 |
| | 6 | **Чиглэл өгөх тухай**<br>2015-05-29<br><br>4 Оюу толгой ордыг ашиглахад Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг гуйвуулалтгүй мөрдүүлэх, цаашид Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах | | Оюу толгойн ордыг ашиглах талаар холбогдох хууль (Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хууль гэх мэт) , тогтоомж ("Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" УИХ-ын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоол), дүрэм (Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм), журмыг (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай) мөрдүүлэн ажиллаж байна.<br>/Биелэлт-100 %/ | 100 |
| **3.г. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2015-01-29<br><br>9/ 9/Эрдэс баялгийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах уялдаа холбоо бүхий “нэг цонхны бодлоготой” болох; | УУБГ | Эрдэс баялгийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах уялдаа холбоо бүхий “нэг цонхны бодлоготой” болох зорилтын хүрээнд "Эрдэс баялгийн бирж байгуулах тухай" Засгийн газрын 2014 оны 211 дүгээр тогтоолын дагуу Эрдэс баялгийн биржийн эрхзүйн орчныг бүрдүүлэхээр Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж Засгийн газрын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Уул уурхайн сайд, Хууль зүйн сайдад даалгасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу хуулийн төслийг боловсруулж Уул уурхайн сайдын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1/297 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн болович УИХ-аар хэлэлцүүлж амжилгүй бүрэн эрхийн хугацаа дууссан.<br>Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дугаар тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн баримт бичигт Эрдэс баялгийн түүхий эдийн биржийг байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох "Эрдэс баялгийн биржийн тухай хууль"-ийг хариуцан боловсруулах байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам байхаар тусгасан байна. **ХЯНАЛТААС ХАСУУЛАХ** | /-/ |
| **3.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл** | | | | | |
| 1 | 1 | **Таван толгойн талаар авах зарим арга хэмжээний талаар**<br>2015-02-16<br>3 Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар өмнө гаргасан Улсын Их Хурал, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн уялдааг сайжруулах, төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд саадгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах | УУБГ<br>ЭТТ | Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар 2007 - 2017 онд Улсын Их Хурлын 27,40,11,32,39,37,69,57,18,37,18,34 дугаартай 14 тогтоол, ЗГ-ын 51, 320, 06, 272, 350, 98, 257, 8, 93, 96, 116, 144, 154, 161, 167, 181, 201, 218, 84, 120, 138, 148, 71, 100, 80, 129, 131, 132, 319,328, 91, 133, 177, 268, 151, 154 дугаартай 36 тогтоол, Засгийн газрын 75, 4, 6, 2, 19, 20, 24, 30, 44, 59, 18, 31, 52, 13, 18, 31, 35, 36, 67, 108, 16, 22, 26 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 06 сарын 07-ны өдрийн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт заасан Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэх, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Таван толгойн ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2 | **Таван толгойн талаар авах зарим арга хэмжээний талаар**<br>2015-02-16<br>4 Монгол Улсын иргэдэд олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэнд оруулж, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж "Эрдэнэс тавантолгой"ХК-ийн хувьцааны эзэмшилийн бүртгэлийг бүрэн хийж дуусгасан. Ингэснээр Монгол Улсын иргэдэд олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэнд оруулах, хувьцааны ногдол ашгийг хүртээх боломж бүрдэж байна. | 100 |
| 2 | 3 | **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар**<br>2010-05-18<br>1 Монгол Улсын Засгийн газраас ордыг ашиглах үзэл баримтлалыг Улсын Их Хуралд танилцуулах баримт бичигт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалт чиглэлийг тодруулан тусгаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны болон шинжээчдийн санал, дүгнэлтийг тухай бүр харгалзан хэлэлцэж байх, | УУБГ ЭТТ | Ерөнхий сайдын 2016 оны 104 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж ахлан ажилласан. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичиг нь нууцын зэрэгтэй тул зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй. | 70 |
| | 4 | **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар**<br>2010-05-18<br>2 Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр алдаа мадаггүй боловсруулах, | УУБГ ЭТТ | Ерөнхий сайдын 2016 оны 104 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж ахлан ажилласан. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичиг нь нууцын зэрэгтэй тул зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр боловсруулах асуудлыг УУХЯ-ны ТЗУГ-ын Хуулийн хэлтэс хариуцан ажиллаж байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 5 | **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар**<br>2010-05-18<br>3 Өнгөрсөн хугацаанд болон цаашид Тавантолгойг сонирхсон гадаадын<br>хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, саналыг Засгийн газар,<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж, хувийн хэрэг үүсгэж, ажлын<br>хэрэгцээнд ашиглаж байх, | УУБГ ЭТТ | Ерөнхий сайдын 2016 оны 104 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж ахлан ажилласан. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичиг нь нууцын зэрэгтэй тул зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй. | 70 |
| | 6 | **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар**<br>2010-05-18<br>4 Урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулах, хэлэлцээ хийх ажлын хэсгийг тус тусад нь байгуулж ажиллуулах.<br>Хэлэлцээ явуулахдаа мэргэжлийн зохих түвшинд хадгалж, улс төрийн албан<br>тушаалтанг хэлэлцээрийн аль нэг талд оролцуулахгүй байх зарчмыг баримтлах. | УУБГ ЭТТ | Ерөнхий сайдын 2016 оны 104 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж ахлан ажилласан. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичиг нь нууцын зэрэгтэй тул зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй. | 70 |
| | 7 | **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар**<br>2010-05-18<br><br>5 Тавантолгойн уурхайн ашиглалт, дэд бүтэц барьж байгуулах асуудлыг "Өмнийн говь" төсөлтэй уялдуулан Улсын Их Хуралд оруулах. | УУБГ ЭТТ | Ерөнхий сайдын 2016 оны 104 захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж ахлан ажилласан. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичиг нь нууцын зэрэгтэй тул зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах эрхтэй. | 70 |
| **3.е. Засгийн газрын тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**<br>2014-09-18 №306<br>2 Гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | УУБГ | Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай шийдвэр гарснаас хойш хууччнаар УУЯ, өнөөгийн УУХҮЯ-аас гаалийн тарифтай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно. | /-/ |
| 2 | 2 | **Хөрөнгө гаргах тухай**<br>2015-04-20<br>1 Гацууртын алтны ордыг ашигласны улмаас Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргахад зориулан 57,241,000.0 (тавин долоон сая хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад зөвшөөрч, орд ашиглалтад орсон тохиолдолд уг хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай. | УУБГ | Ерөнхий сайды 2015 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 55 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг Шинжлэх ухааны академийн Палеонтологи, Геологийн хүрээлэн судалж тайлан гарган 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Т/16 дугаартай албан бичгээр палеонтлогийн хайгуул судалгааны ажлын дүгнэлтийг Гацууртын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч "Сентерра гоулд Монголиа ХХК-д хүргүүлсэн байна. Энэхүү судалгааны дүгнэлтэд "палеонтологийн олдвор зөвхөн Голоцены сэвсгэр хурдсаас илрэх магадлалтай харин бусад палезойн хурдсууд ямарч олдвор агуулаагүй гэдгийг дурдсан байна. Холбогдох зардлыг Сентерра гоулд Монголиа ХХК-тай байгуулах орд ашиглах гэрээний төсөлд тусгасан бөгөөд Гацууртын алтны орд ашиглах асуудал шийдэгдээгүй байна. Биелэлт 90% | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 3 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 №: 2014_268<br><br>1.а Төрийн өмчит “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн эзэмшилд байгаа Таван толгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн мэдэлд шилжүүлэхгүйгээр “Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд бүрэн ашиглуулах; | УУБГ | Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын “Чайна Шенхуа Энержи” ТӨК (цаашид “Шеньхуа” гэх), Японы “Сумитомо корпораци” болон Монголын “Mongolian Mining Corporation” (цаашид “ММС” гэх) компанийн хамтарсан консорциум шалгарсан.<br>Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг ажилласан.<br>Ажлын хэсэг Консорциумтай байгуулахаар төлөвлөж байсан “Хамтын ажиллагааны гэрээ”, “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Ухаа худаг-Гашуун Сухайт чиглэлд төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх гэрээ”-г судлан дүгнэлт гаргаж, саналыг Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан.<br>Ажлын хэсгийн саналыг дараах байдлаар судлаж, Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 30-ийн өдрийн 181 дүгээр тогтоол болон 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 268 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн. Ингэснээр тус компанийн 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн хууль ёсны эрх ашиг хангагдаж, 2010 онд зарласан Таван толгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтын хураангуй жагсаалтанд багтсан 6 компанийг дахин хууль, тогтоомжид нийцүүлэн сонгох боломж нээлттэй үлдэнэ гэсэн дүгнэлт гаргасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Дээрх Ажлын хэсэг Тавантолгойн ордод төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит “Монголын төмөр зам” ХК эзэмшин төрийн оролцоо, хяналтыг хангах, тодорхой хугацааны дараа үлдсэн 49 хувийг төрийн өмчийн компанид үнэ төлбөргүй шилжүүлэх, Тавантолгойн ордоос олборлосон нүүрсийг боловсруулж, нэмүү өртөг шингээх замаар БНХАУ болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлох зарчмыг баримтлан ажиллаж байна. Энэхүү зарчмын саналыг Хөрөнгө оруулагч талд 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдөр хүргүүлсэн боловч одоог хүртэл тодорхой хариу ирүүлээгүй байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 №: 2014_268 1.б Хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлох, тэдгээр талбайд нэмэлт хайгуул хийж нөөцийг нэмэгдүүлэх; | УУБГ | Баруун болон Зүүн Цанхийн талбайд стартегийн хөрөнгө оруулагч нь сонгогдоогүй учир дээрх хайгуулын нэмэлт ажил хийгдээгүй болно. | /-/ |
| | 5 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 №: 2014_268<br><br>1.в Хөрөнгө оруулагчаар сонгогдон ажиллах эхний 2,5 жилийн хугацаанд багтаан Таван толгойн бүс нутагт 30.0 сая тонноос багагүй нүүрсийг баяжуулах хүчин чадлыг бий болгох, үйлдвэрлэсэн баяжмалыг 2-оос доошгүй орны зах зээлд нийлүүлэх; | УУБГ | Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 тоот захирамжаар байгуулагдсан Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулж, хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсгээс Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпораци нартай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хэлэлцээрийг эхлүүлсэн бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр мөн дахин уулзалт хийж тус уулзалтын үеээр удирдамжид заасан асуудлаар хэд хэдэн гол асуудлуудыг Монголын талын зүгээс санал болгосон бөгөөд Үүнд:"...-Борлуулалтын доод хэмжээ нь жил бүр 22.5 сая тонноос доошгүй баяжуулсан нүүрс байх" тухай тусгасан /2013 оны 6 сарын 13-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хүлээж авсан Тавантолгойн ордын цанхийн зүүн хэсгийн уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д жилд 20 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар тооцсон/. Хөрөнгө оруулагчдын зүгээс ямар нэг хариу ирүүлээгүй байна. Иймд хөрөнгө оруулж, хамтран ажиллах талын ямар саналтай байгааг тодорхойлох боломжгүй байна. Биелэлт 50% | 30 |
| | 6 | **Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай** 2014-08-20 1.г Хөрөнгө оруулагч нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-иас БНХАУ-ын “Чалко” компанид төлөх өр төлбөрийн үлдэгдлийг хариуцан барагдуулж, тус компанитай байгуулсан гэрээний үүргийг хариуцах; | УУБГ ЭТТ | 2016 онд Чалко компаний төлбөрт 39 сая ам долларыг төлж оны эцэст 76.5 сая ам доллар болгон бууруулсан.2017 оны 03 дугаар сарын 31-нд Чалка компаний өр төлбөрийг бүрэн барагдуулж дууссан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 7 | **Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2014-08-20<br><br>1.д Хөрөнгө оруулагч нь улсын төсөвт төлөх татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хариуцахаас гадна борлуулалтын орлогын тодорхой хувийг Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний төлбөрт төлөх, шаардлагатай тохиолдолд нэмж төлөх борлуулалтын орлогын тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр хэлэлцэх; | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: "...Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Тавантолгой зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх, иргэдийн эзэмшиж буй 1,072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгох, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах..."-аар тусгасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар "Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг" байгуулагдсан. Ажлын хэсэг Тавантолгойн ордод төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит "Монголын төмөр зам" ХК эзэмшин төрийн оролцоо, хяналтыг хангах, тодорхой хугацааны дараа үлдсэн 49 хувийг төрийн өмчийн компанид үнэ төлбөргүй шилжүүлэх, Тавантолгойн ордоос олборлосон нүүрсийг боловсруулж, нэмүү өртөг шингээх замаар БНХАУ болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлох чиглэл баримталж, энэ талаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах талуудад тодорхой саналыг 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдөр хүргүүлээд байна.<br>Биелэлт 90% | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 8 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай**<br>2016-04-04 №196<br><br>3 Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Өмнөговь аймгийн Засаг дарга Д.Бадраа нарт үүрэг болгосугай. | УУБГ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “...Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Тавантолгой зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх, иргэдийн эзэмшиж буй 1,072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгох, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах...”-аар тусгасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг” байгуулагдсан. Ажлын хэсэг Тавантолгойн ордод төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит “Монголын төмөр зам” ХК эзэмшин төрийн оролцоо, хяналтыг хангах, тодорхой хугацааны дараа үлдсэн 49 хувийг төрийн өмчийн компанид үнэ төлбөргүй шилжүүлэх, Тавантолгойн ордоос олборлосон нүүрсийг боловсруулж, нэмүү өртөг шингээх замаар БНХАУ болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлох чиглэл баримталж, энэ талаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах талуудад тодорхой саналыг 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдөр хүргүүлээд байна.<br>Биелэлт 90% | 70 |
| 5 | 9 | **Талбайг нөөцөөс чөлөөлөх тухай**<br>2016-04-18 №214<br>2 Нөөцөөс чөлөөлсөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Оюут уул”, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших “Эрдэнэт-Зүүн хойд-3” талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгасугай. | УУБГ | Холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 10 | **“Шивээ-овоо” ХК-ийн техник, технологийг шинэчлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх тухай**<br>2016-04-18 №219<br><br>2 “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай. | УУБГ | Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн нүүрсний хэрэгцээ, найдвартай ажиллагааг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн өмчийн оролцоотой “Шивээ-Овоо” ХК-ийн санхүү, эдийн засгийн байдал хүндэрч, өөрийн хөрөнгөөр техник, технологийн шинэчлэл хийх боломжгүй болж, уурхайн хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрээд байна. Иймд Шивээ-Овоогийн уурхайн техник, технологийн шинэчлэлтийн төслийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулах хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Шивээ-Овоо ХК 7.5 тэрбум төгрөгийн төсвийн болон арилжааны банкны зээлийн үлдэгдэлтэй байна. Дээр зээлийн үлдэгдлийг компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөнд үе шаттай барагдуулахаар төлөвлөөд байна.<br>Биелэлт 100% | 100 |
| 7 | 11 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай**<br>2016-08-03 №14<br><br>3 Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт даалгасугай. | УУБГ | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд зааснаар /11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;/ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хуулийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>Биелэлт 100 хувь | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 12 | **Тогтоол хүчингүй болгох тухай 2017-03-20 №96**<br>4.Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганц мод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | УУБГ ЭТТ | Гашуун Сухайтын Төмөр Зам" ХХК-д оруулсан хувь хөрөнгийн хэмжээг татан авах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, холбогдох дүгнэлтийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. ТУЗ-өөс хувь хөрөнгөө татан авах ажлыг гүйцэтгэхийг даалгасан тогтоолыг 2017 оны 05 дугаарсарын 25-нд гаргасан. Үүний дагуу "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт" аудитын шалгалт хийлгэх зардлыг шийдвэрлэж өгөх тухай хүсэлтийг хүргүүлээд байна. | 70 |
| 9 | 13 | Журам батлах тухай<br>2017-02-22 №: 2017_61<br><br>2 Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт даалгасугай. | УУБГ | "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Журам батлах тухай" Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, энэ ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрийн хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 613 дугаар шийдвэрээр 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн UN-000001 дугаартай үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг "Ачит Ихт" ХХК-д олгосон. Мөн ЭБМЗ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Ачит Ихт" ХХК-ийн Үүсмэл ордын нөөцийн тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргахад оролцсон.<br>/Биелэлт 100%/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 14 | "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-05-30 №: 2017_154<br><br>1. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардалгтай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ /Б.Даажамба/-д даалгасугай. | УУБГ ЭТТ | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардлагатай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам тээврийн яам, Эрчим хүчний яам, Үндэсний хөгжлийн газар, Эрдэнэс Монгол ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулаад байна.<br>Ажлын хэсэг нь "Эрдэнэс Монгол" компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, уул уурхайг дагасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийн төслийг хөгжүүлэх чиглэлээр дунд хугацааны стратеги, үйл ажиллгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.<br>/Биелэлт 30%/ | 30 |
| | 15 | "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-05-30 №: 2017_154<br><br>8. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүү, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва нарт тус тус даалгасугай; 8.1. Оюуны өмч, улсын бүртгэлийн | УУБГ ЭТТ | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, "Эрдэнэс Тавантолгой" ХК зэрэг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж санал дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн саналын дагуу Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшийгчийн мэдээллийг тулгаж "Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн хувьцааны эзэмшигчдийн бүтцийг дараах байдлаар бүртгээд байна. Үүнд:<br>Хувьцаа эзэмшигч — Хувьцааны тоо — Дүнд эзлэх хувь<br>Эрдэнэс Монгол ХХК — 9,780,711,099 — 65.2%<br>ААН — 7,065,038 — 0.05%<br>Иргэд — 2,212,223,863 — 14.75%<br>Зарласан хувьцаа — 3,000,000,000 — 20.0%<br>**12,000,000,000**<br>Хувьцаа эзэмшигчдийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дэх | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ероөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаанаас хишиг хувь хүртсэн болон Засгийн газарт нэрлэсэн үнээр хувьцаагаа худалдсан иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанд нэмэгдүүлэн бүртгэж, шинээр хувьцаа эзэмших болон хувьцаагаа буцаан худалдан авах хүсэлт гаргаж төлбөрөө шилжүүлсэн иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанаас шилжүүлэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг цэгцлэх ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хэрэгжүүлэх; 8.2. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг үндэслэн хувьцааны нэрэлсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, нийт гаргасан хувьцааг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүүгийн тайланд тусгах; 8.3. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэр бүртгэж, нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, санхүүгийн тайланд тусгах; | | бүртгэлд нэр заан бүрэн бүртгэсэн.<br>/Биелэлт-100%/ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | 16 | **Төв, суурин газрын 2017 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2017-06-28<br>7. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангахад хүрэлцэхүйц хэмжээний дизель түлш, шатахууны нөөц бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийж дуусган, авахад бэлэн нүүрсний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах талаар холбогдох арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрчим хүчний сайд П.Ганхүү, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгасугай. | УУБГ | Багануур" ХК," "Шивээ-Овоо" ХК-уудад авахад бэлэн нүүрсний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах талаар үүрэг өгч, мэдээг тогтмол авч ажиллаж байна.<br><br>“Багануур” ХК нь 2017 онд нийт 18.7 сая.м3 хөрс хуулалтын ажил хийхээр төлөвлөж 20.74 сая.м3 хөрс хуулж гүйцэтгэл 110.8 хувьд хүрээд байна. 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 3.36 сая тонн нүүрс олборлохоос 3.53 сая тонн нүүрс олборлож, төлөвлөгөөний биелэлт 105.06 хувь, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 3.36 сая тонн, борлуулалтын хэмжээ 3.52 сая тоннд хүрч төлөвлөгөөний биелэлт 104.8 хувьд хүрээд байна. Авахад бэлэн нүүрсний нөөцийн хэмжээ 4.38 сая тонн. Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 67 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хийгдсэн-60, гүйцэтгэж байгаа-5, хойшлуулсан-2 нийт 99 хувийн гүйцэтгэлтэй байна. "Багануур"ХК нь Дулааны 4-р цахилгаан станц /ДЦС-4/, ДЦС-3, ДЦС-2, Дарханы ДЦС, Багануурын ДС, Амгалангийн ДС-ын эрчим хүчний нүүрсний хэрэглээг хангаж байна. “Шивээ-Овоо” ХК нь2017 онд нийт 8.22 сая.м3 хөрс хуулахаар төлөвлөснөөс 7.15 сая.м3 хөрс хуулж төлөвлөгөөний биелэлт 87 хувьд хүрээд байгаа бол 2017 онд нийт 1.95 сая тонн нүүрс олборлож, борлуулахаар төлөвлөснөөс 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар өссөн дүнгээ 2.03 сая тонн нүүрс олборлож, 1.99 сая тонн нүүрс борлуулж, нүүрс олборлолтын төлөвлөгөө 104.1 хувь, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 102.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Авахад бэлэн нүүрсний нөөцийн хэмжээ 200 мянган тонн Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 42 арга хэмжээ төлөвлөснөөс хийгдсэн ажил-34, хойшлогдсон-2, санхүүжилт шийдэгдээгүй-2, нийт ажлын гүйцэтгэл 75 хувьд хүрээд байна. Тус компани ДЦС-4, Налайхын ДС, Бор-Өндрийн УБҮ, УБТЗ, Дорноговь ДС, Говьсүмбэр ДС болон бусад хэрэглэгчдийг эрчим хүчний нүүрсээр хангаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | 17 | **Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017-11-29, № 320** Нүүрсний тээвэрлэлтэд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг арилгах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-эрдэнэ, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт даалгасугай.<br>1.1. Гашуунсухайт-Ганц модны хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэмэгдэх хүртэлх түр хугацаанд нүүрсний тээвэрлэлтийг Таван толгойн нүүрсний ордоос Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл, Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайт боомт хүртэл чиглэлээр тус тус зохион байгуулах;<br>1.2. Хилийн боомтоор нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн тоо хэмжээтэй уялдуулан нүүрсний ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зохицуулалт хийх | | Засгийн газрын 2017 оны 320 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, нүүрсний тээвэрлэлттэй холбоотой үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг арилгах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/233 дугаар тушаалаар байгуулж, Ажлын хэсгийн хурлаас гаргасан ажил үүргийн хуваарийн дагуу Гашуунсухайтын хилийн боомт хүртэлх нүүрсний тээвэрлэлт хийж байгаа тээврийн байгууллагуудын тээвэрлэлтэд гаалийн бүрдүүлэлт хийхийг түр хугацаанд зогсоох шийдвэрийг Гаалийн ерөнхий газарт 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлж , уурхайнуудын нүүрсний ачилт, тээвэрлэлт болон Гаалийн бүрдүүлэлтийг 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түр хугацаанд зогсоосон. Мөн ажлын хэсгийн зарим гишүүд 2017 оны 12 дугаар сарын 12-ноос 15-ны өдрүүдэд Гашуунсухайтын авто замын нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, холбогдох арга хэмжээг авч ажиллав. Гашуун сухайт авто замын ачааллыг бууруулж, авто машины урт дараалллын багассантай холбогдуулан Ажлын хэсгийн хурлыг 2017.12.21-ний өдөр хуралдуулж, хурлаас гарсан 1.Тавантолгойн бүлэг ордоос Гашуунсухайт боомт хүртэл экспортын нүүрсний тээвэрлэлт хийж буй Эрдэнэс таван толгой ХК, Энержи ресурс ХХК, Тавантолгой ХК-иудын эзэмшлийн уурхайнуудаас Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл (уртын рейс) нүүрсний ачилт тээвэрлэлтийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 08:00 цагаас эхлүүлэх;<br>2. Дээрх компаниудын Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайтын боомт хүртэл (богинын рейс) нүүрсний ачилт, тээвэрлэлт болон гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг 2017оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 14:00 цагаас тус тус эхлүүлэх тухай шийдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 01/2688 дугаар "Чиглэл өгөх тухай" албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. /Биелэлт 100%/ | 100 |
| **3.ё. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийх**<br>2016-11-16 № 104<br><br>2 Энэхүү захирамжийн 2 дугаар хавсралтад заасан удирдамжийн хүрээнд хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж явцыг 14 хоног тутам танилцуулан, дүнг холбогдох гэрээний төслийн хамт 2016 оны 12 дугаар сарын 31-ний дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “...Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Тавантолгой зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх, иргэдийн эзэмшиж буй 1,072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгох, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах...”-аар тусгасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг”-ийг байгуулж, Ажлын хэсгийн удирдамжийг баталсан бөгөөд Ажлын хэсэг дараах үндсэн хэд хэдэн чиглэлээр хөрөнгө оруулагчтай хэлэлцээг хийж байгаа болно. Үүнд: (i) Төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал, 49-өөс дээшгүй хувийг Шэнхуа групп тус тус эзэмших бөгөөд Тавантогойн ордоос олборлосон нүүрсийг БНХАУ-ын болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлж, тохиролцох, (ii) Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит компани эзэмших, (iii) Төмөр замын суурь бүтцийг 2.5 жилийн хугацааны дотор барьж, ашиглалтад оруулах, төсөл хэрэгжиж дууссаны дараа төмөр замын суурь бүтцийг барьж, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 49 хувийг төрийн өмчит компанид үнэ төлбөргүй эзэмших нөхцөлөөр гэрээ байгуулах; (iv) Ашигт малтмалын тухай хуулийн 35.11-д олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт нэн тэргүүн ээлжид, зах зээлийн үнээр нийлүүлнэ гэж заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч компани нь одоо байгаа угаах үйлдвэрийг ашиглах, хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр үйлдвэр барих замаар нүүрсээ экспортлох, (v) Тавантолгойн ордыг ашиглах ТЭЗҮ-ийг гэрээ байгуулснаас хойш 9 сарын дотор боловсруулах; (vi) Төсөл хэрэгжүүлэгч компанийн Монголын талын хөрөнгө оруулагч компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний талаар Монголын талаас оролцогч компанитай тохиролцох гэж тус тус заасан. Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпорац нартай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хэлэлцээрийг эхлүүлэхээр уулзалт хийж хэлэлцээрийг эхлүүлсэн, 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр дахин уулзалт хийж ажлын хэсгийн удирдамжид заасан асуудлаар Монголын талын саналыг хүргүүлээд байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын зүгээс ямар нэг хариу ирүүлээгүй байна.<br>/Биелэлт 90%/ | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | Ажлын хэсэг байгуулах тухай“ Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээбайгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий<br>2017-01-25 №: 2017_20<br><br>2 Хэлэлцээний үр дүнг эцэслэн тохирсон гэрээний төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | УУБГ | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 03 дугаар сарын 30-өдөр хүргүүлсэн. Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголия" ХХК-иас Гацууртын ордын нөөцийг тодотгож батлуулах, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлууах шаардлагтай байгаа тул хүлээгдэж байна. | 70 |
| 3 | 3 | Ажлын хэсэг байгуулах тухай /Гацууртын алтны үндсэн орд<br>2017-01-25 №: 2017_21<br><br>2 Хэлэлцээний явц, үр дүн, орд ашиглах гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж, гэрээг 2017 оны 3 дугаар сард багтаан байгуулах ажлыг удирдан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | УУБГ | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Орд ашиглах гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголия" ХХК-иас Гацууртын ордын нөөц болон Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг батлуулах шаардлагатай байгаа тул уг асуудал хүлээгдэж байна. /Биелэлт 90%/ | 70 |

**3.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **2014 оны 7 сарын 9-ний 38 дугаар тэмдэглэл**<br>2014-07-09<br><br>XYII.3 Шивээхүрэн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөж, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Нарийнсухайтын нүүрсний бүлэг ордоос Шивээхүрэн боомтоор тээвэрлэх нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хилийн боомтоор нэвтрэх авто машины ачааллыг бууруулах, хоёр улсын хилийн гаалийн хамтарсан хяналт хийх боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан нүүрс экспортлогч компаниуд болон нүүрс шилжүүлэн ачих байгууламж, зам барьж байгаа аж ахуйн нэгжүүдтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Зам, тээврийн сайд А.Гансүх, Гадаад харилцааны сайд Л.Болд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт даалгав. | УУБГ | Шивээхүрэн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөх ажил хийгдсэн. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрсний бүлэг ордоос Шивээхүрэн боомтоор тээвэрлэх нүүрсний хэмжээ нэмэгдсэн. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хилийн боомтоор нэвтрэх авто машины ачааллыг бууруулах, хоёр улсын хилийн гаалийн хамтарсан хяналт хийх боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан нүүрс экспортлогч компаниуд болон холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна.<br>Биелэлт 100 хувь | 100 |
| 2 | 2 | | УУБГ | | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл** 2015-03-30<br><br>XXII.2. Гацууртын ордын хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээний явцын талаар Үүнтэй холбогдуулан хэлэлцээг эцэслэх чиглэлээр шуурхай ажиллаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Сентеррагоулд Монголиа” ХХК-тай орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 26, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар захирамжуудаар байгуулагдаж, хөрөнгө оруулагчтай тодорхой түвшинд хэлэлцээр хийж, гэрээний төслийг бэлтгэсэн байдаг. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, дан Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлээд байна. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр”-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг “Сентерра Гоулд Монголиа” ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. Үүний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын гэрээ болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн. Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэх, Улаанбаатар-Дарханы замаас Мандал сум болон Гацууртын уурхай хүртэлх автозамыг хатуу хучилттай болгох, мөн төслийн хөрөнгө оруулалтаас гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хөрөнгө оруулагч талд тавиад байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 3 | **2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр 20 дугаар тэмдэглэл**<br>2015-04-13<br><br>XXIY. 6.1. Оюутолгой төслийг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид татвар, тайлан, балансгай холбогдох маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Оюу толгой" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, стандарттай нийцүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон тус компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ганболд нарт; | УУБГ<br>ЭОТ | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3-д тус тус заасны дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх асуудал нь Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаардаг тул /Хяналтаас хасуулах/ Биелэлт 100 хувь | 100 |
| 4 | 4 | | УУБГ | | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2015 оны 05 дугаар сарын 4-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл** 2015-05-04<br><br>XXI. 2. Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сентерра гоулд Монголиа” ХХК-тай тус ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаар хийж байгаа хэлэлцээний явцын тухай Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгахыг Ажлын хэсэг (Г.Тэмүүлэн)-т даалгав. | | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Сентеррагоулд Монголиа” ХХК-тай орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 26, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар захирамжуудаар байгуулагдаж, хөрөнгө оруулагчтай тодорхой түвшинд хэлэлцээр хийж, гэрээний төслийг бэлтгэсэн байдаг. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, дан Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлээд байна. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр”-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна.<br>Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг “Сентерра Гоулд Монголиа” ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. үний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын гэрээ болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн. Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэх, Улаанбаатар-Дарханы замаас Мандал сум болон Гацууртын уурхай хүртэлх автозамыг хатуу хучилттай болгох, мөн төслийн хөрөнгө оруулалтаас гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хөрөнгө оруулагч талд тавиад байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 5 | **2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 53 дугаар тэмдэглэл**<br>2015-09-28<br><br>XYI. 5. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагч талтай байгуулах гэрээний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнгийн талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулсантай холбогдуулан хөрөнгө оруулагч талаас тавьж байгаа санал, нөхцөлийг тухай бүр танилцуулан уг хэлэлцээг ойрын хугацаанд дуусгах чиглэлээр ажиллахыг Ажлын хэсэг (Б.Бямбасайхан)-т даалгав. | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “...Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Тавантолгой зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх, иргэдийн эзэмшиж буй 1,072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгох, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах...”-аар тусгасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг”-ийг байгуулж, Ажлын хэсгийн удирдамжийг баталсан бөгөөд Ажлын хэсэг удирдамжид заасан асуудлаар Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпорац нартай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хэлэлцээрийг эхлүүлсэн бөгөөд дараах үндсэн хэд хэдэн чиглэлээр хөрөнгө оруулагчтай хэлэлцээг хийж байгаа болно. Үүнд: " БНХАУ-ын зах зээлд борлуулалт хийх Худалдааны хамтарсан компанийн гаргасан болон зарласан хувьцааны 35 хувийг Засгийн газар үнэ төлбөргүй эзэмшинэ. Гуравдагч зах зээлд борлуулалт хийх Худалдааны хамтарсан компанийн гаргасан болон зарласан хувьцааны 12 хувийг Засгийн газар үнэ төлбөргүй эзэмших" гэх мэт удирдамжид заасан асуудлаар Монголын талын саналыг 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хөрөнгө оруулж хамтран ажиллах талд хүргүүлээд байна.<br>**/ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ/** | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 6 | 2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2016-03-28 №: 2016_18<br><br>XIX.12. Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, санал зөрүүтэй асуудлуудаар тохиролцсоны үндсэн дээр 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | УУБГ | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. /Биелэлт 90%/ | 70 |
| 7 | 7 | | УУБГ | | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>2016-04-18<br><br>XXYIII.4. Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Сентеррагоулд Монголиа” ХХК-тай орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 26, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар захирамжуудаар байгуулагдаж, хөрөнгө оруулагчтай тодорхой түвшинд хэлэлцээр хийж, гэрээний төслийг бэлтгэсэн байдаг. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, дан Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлээд байна. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр”-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг “Сентерра Гоулд Монголиа” ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. Үүний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын гэрээ болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн. Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэх, Улаанбаатар-Дарханы замаас Мандал сум болон Гацууртын уурхай хүртэлх автозамыг хатуу хучилттай болгох, мөн төслийн хөрөнгө оруулалтаас гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хөрөнгө оруулагч талд тавиад байна. | |
| 8 | 8 | | УУБГ | | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 35 дугаар тэмдэглэл** 2016-06-20<br><br>IX. 3. “Багануур” ХК-ийн бэлтгэгдсэн мэргэжлийн ажиллах хүчин, нөөц бололцоонд тулгуурлан үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, хуримтлагдсан өр авлагыг бууруулах зорилгоор Тавантолгойн нүүрсний ордын “Баруун цанх”-ийн хэсэгт хөрс хуулах, нүүрс олборлох ашиглалт явуулах талаар дээрх компанийн удирдлагаас тавьсан хүсэлтийг хэрэгжүүлэх боломжийг судлан саналаа танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарт даалгав. | | "Эрдэнэс Таван толгой" ХК төрийн өмчит компани тул тус компаний харъяа уурхайд үйл ажиллагаа явуулахад сонгон шалгаруулалтын үндсэн дээр гүйцэтгэгчийг сонгодог. Уг сонгон шалгаруулалтаар Багануур ХК шалгараагүй байна<br>Биелэлт 100% | |
| | 9 | **2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 35 дугаар тэмдэглэл** 2016-06-20<br><br>YII. Монгол Улсын Засгийн газар болон “Тавантолгой цахилгаан станц” ХХК-ийн хооронд байгуулах “Тавантолгой цахилгаан станц төсөл”-ийн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцээд асуудлыг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Эрчим хүчний яам, Гадаад хэргийн яам болон бусад яамдын саналыг судлан тусгаж, хууль тогтоомжид нийцүүлсний үндсэн дээр Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг | УУБГ | “Тавантолгой цахилгаан станц төсөл”-ийн Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд 2016 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын тухай” хууль, “Концессын тухай” хууль болон Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-д нийцүүлж, дотоодын зөвлөх, үндэсний мэргэжилтнүүд, сонирхлын зөрчилгүй мэргэжлийн байгууллагуудын саналыг тусгах нь зүйтэй зэрэг тодорхой 10 саналыг Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжид хүргүүлсэн.<br>"Оюу толгой"ХК нь 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж 2017 оны 7 дугаар сараас эхлэн эрчим хүчний нийт хэрэглээг зөвхөн дотоодын эх үүсвэрээс хангах үүрэг хүлээсэн.<br>Уг асуудлыг Уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын эрх үүрэгт хамаарахгүй, Эрчим хүчний яамны хариуцах ажил тул **ХАСАХ САНАЛТАЙ** . | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зурахыг Монгол Улсын сайд М.Энхсайханд даалгав. | | | |
| 9 | 10 | **2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>2016-11-30<br>XIII.9. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлын явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах консорциумд монголын тал 51-ээс дээш хувийг эзэмшихтэй холбоотой асуудал болон Тавантолгойн ордыг үр ашигтай ашиглах талаар судалгаа хийж оновчтой хувилбар боловсруулан танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгав. | УУБГ ЭТТ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “...Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Тавантолгой зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлэх, иргэдийн эзэмшиж буй 1,072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгох, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах...”-аар тусгасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг”-ийг байгуулж, Ажлын хэсгийн удирдамжийг баталсан бөгөөд Ажлын хэсэг дараах үндсэн хэд хэдэн чиглэлээр хөрөнгө оруулагчтай хэлэлцээг хийж байгаа болно. Үүнд: Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпорац нартай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хэлэлцээрийг эхлүүлсэн, 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр дахин уулзалт хийж ажлын хэсгийн удирдамжид заасан асуудлаар Монголын талын " БНХАУ-ын зах зээлд борлуулалт хийх Худалдааны хамтарсан компанийн гаргасан болон зарласан хувьцааны 35 хувийг Засгийн газар үнэ төлбөргүй эзэмшинэ. Гуравдагч зах зээлд борлуулалт хийх Худалдааны хамтарсан компанийн гаргасан болон зарласан хувьцааны 12 хувийг Засгийн газар үнэ төлбөргүй эзэмшинэ" гэх мэт саналыг хүргүүлээд байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын зүгээс ямар нэг хариу ирүүлээгүй байна. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 11 | **2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл**<br>2017-06-28<br><br>XI.3. Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийг чөлөөлөх асуудлыг судлан санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгав. | УУБГ | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 187 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч ”Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалтай танилцах, хүндрэлтэй асуудлыг судалж, шийдвэрлэх талаар холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан тушаалаар байгуулах саналыг боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр УУХҮСайд Ц.Дашдоржид танилцуулсан бөгөөд Ажлын хэсгийн хүрээнд асуудлыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Багануурын уурхайн техник, технологийн шинэчлэлтийн төсөл”, “Шивээ-Овоогийн уурхайн техник, технологийн шинэчлэлтийн төсөл”-ийг хамруулах тухай хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн<br>/Биелэлт-50%/ | 70 |
| 11 | 12 | **2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл**<br>2017-08-17<br><br>XYI.8. 2. Нүүрсний экспорттой холбоотой асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд гарч байгаа саатлыг арилгах талаар хятадын талтай хэлэлцэн шийдвэрлэхийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав. | УУБГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн. 2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн.<br>/Биелэлт-100%/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | 13 | **2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 38 дүгээр тэмдэглэл** 2017-08-31<br><br>YIII. 2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад дахь гаалийн хяналтын бүсийг цаашид ажиллуулах шаардлагатай эсэх асуудлыг судалж, уг бүс нутгийг хөгжүүлэх, иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, холбогдох саналаа 2017 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуучлалын сайд Д.Оюунхорол, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат нарт даалгав. | УУБГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Л.Энхболд нарын хамт Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн бүлэг ордоос Гашуун сухайт хилийн боомт хүртэлх 247 км авто зам дээр нүүрс тээвэрлэлттэй холбоотойгоор үүссэн хүндрэлтэй асуудал болон хилийн боомтын үйл ажиллагаатай биечлэн танилцсаны дагуу "Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл танилцуулгын хамт бэлтгэн, яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2510 тоот албан бичгээр тогтоолын төсөл, танилцуулгыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэн "Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 320 дугаар тогтоолыг баталсан.<br>/Биелэлт-100%/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 14 | **2017 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2017-11-08 №: 2017_47**<br><br>YI.1. “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд тусгасан өөрийн эрхлэх ажлын хүрээний төсөл, арга хэмжээтэй нэг бүрчлэн танилцаж, холбогдох саналаа 2017 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | УУБГ | Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг тусгах ажлын хүрээнд Тавантолгойн бүлэг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэхэд шаардлагатай дэд бүтэций төслүүд болох Хэрлэн голын урсацад тохируулга хийх төсөл, Тавантолгой-Сайншандын төмөр зам, Тавантолгой Гашуунсухайт,төмөр зам, Тавантолгой-Ханги-Мандалын авто зам, Тавантолгой-Цагаан дэлийн авто зам, Оюутолгойн уурхайг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 5-р зөрлөгтэй холбох 41км төмөр зам, Баруун-Урт- Бичигтийн авто зам, Бичигт -Хөөтийн төмөр замын төслүүд, Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах төсөл, Рашаант дахь улсын нөөцийн агуулах барих төсөл, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл, Монгол орын геологи-геофизикийн судалгааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл, Монгол орны үндэсний геопаркууд байгуулах төсөл болон зураг төсөл, техник эдийн засгийн судалгааны саналыг холбогдох танилцуулгын хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2570 дугаар албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. /Биелэлт-100%/ | 100 |
| 14 | 15 | **2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2017-11-15 №: 2017_48**<br><br>X.4. 1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн талбайн үйл ажиллагаа, экспортод гаргах нүүрсний тээвэрлэлтэд зохицуулалт хийх боломжийг судлан санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгав. | УУБГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Л.Энхболд нарын хамт Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн бүлэг ордоос Гашуун сухайт хилийн боомт хүртэлх 247 км авто зам дээр нүүрс тээвэрлэлттэй холбоотойгоор үүссэн хүндрэлтэй асуудал болон хилийн боомтын үйл ажиллагаатай биечлэн танилцсаны дагуу "Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл танилцуулгын хамт бэлтгэн, яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2510 тоот албан бичгээр тогтоолын төсөл, танилцуулгыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэн "Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 320 дугаар тогтоолыг баталсан. /Биелэлт-100%/ | 100 |
| **ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО** | | | | | |
| **4.б. Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах тухай**<br>**2010-04-29 №: 02_2010_21**<br><br>4 зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг 2011 оны эхний хагас жилд багтаан хангах.<br>3. зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга, хэлбэрийг тодорхойлох; | 4. ЭБЭХ-ны сайдын 2010 оны 162 дугаар тушаалаар Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барьж байгуулах боломж, нөхцөлийн талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, УИХ-ын ЭЗБХ-ны 2010 оны 5-р сарын 18 өдрийн хуралдаанд ЭБЭХЯ-ны сайд Д.Зоригт энэ тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийсэн ба ажлын хэсгийн дүгнэлтээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэж буй зэсийн баяжмалд түшиглэн жилд 90-130 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг Ausmelt болон Isasmelt технологиор, “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд жилд 200 мянган тонноос дээш катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг барихдаа Финлянд улсын “Outotec” компанийн Flashsmelt технологийг сонгох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд технологийн эцсийн сонголтыг нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлно" гэсэн дүгнэлт гаргасан. 3. Аж үйлдвэрийн яамнаас Засгийн газрын 2015 оны “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 247 дугаар тогтоол батлуулж, үйлдвэрийг Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байгуулахаар байршилыг тогтоосон. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр”-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2013 оны 03 сарын 13 өдрийн А\161 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг БНХАУ-ын “Volant Industry” компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төсөл боловсруулах институт /ENFI/-тэй хамтран боловсруулж, Аж үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр батлуулсан. Мөн Засгийн газрын 2016 оны "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай" 318 дугаар тогтоол гарч Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоосон. 2016 онд шинэ Засгийн газар байгуулагдсанаар Засгийн газрын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолыг баталж, Засгийн газрын 2015 оны 247, 2016 оны 318 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгон, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулах, үйлдвэрийн нийт хувьцааны арваас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмшихээр тогтоосон. Засгийн газар өөрчлөгдөн дараагийн Засгийн газруудаас удаа дараа тогтоол гарган өмнөх тогтоолоо хүчингүй болгон , "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн байршил, боловсруулах баяжмалын эх үүсвэр, үйлдвэрийн хүчин чадал зэрэг өөрчлөгдөж байгаа нь төслийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа ба 2010 онд батлагдсан УИХ-ын дээрх тогтоол цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдсан, дээрх Засгийн газрын тогтоолуудын заалттай утга, агуулга | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нэг байгаа тул тогтоолыг хяналтаас хасуулах саналтай байгаа болно. **ХЯНАЛТААС ХАСАХ** | |
| 2 | 2 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2015-02-17<br><br>10 10/ цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах; | “Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах” төслийн хүрээнд, "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь Төмөртолгой, Төмөртэй, Хуст-Уулын төмрийн хүдрийн ордуудаа түшиглэн төмрийн хүдрийг боловсруулж, төмөрлөг түүхий эдийн хомсдлыг багасгах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг ихэсгэх, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх, “Уул уурхай металлургийн цогцолбор” байгуулахаар ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) болон Олон улсын хөгжлийн нийгэмлэг (Дэлхийн банк)-ийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл" (УУДБХОД)-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дараахь ажлууд хийгдээд байна. Үүнд: | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 1. “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” –ийн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)<br>2. “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) /хийгдэж байна<br>3. "Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн Техник эдийн засгийн үндэслэл<br>4. “Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” /хийгдэж байна/<br>Дээрхи ажлуудын хүрээнд төслийг хэрэгжүүлэх, зөвлөх компаниудыг ”Дэлхийн банкны зээлдэгчид зөвлөх сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ын дагуу сонгон шалгаруулсан. Үүнд:<br>1. Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 сарын 06-ны өдрийн 273 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтэцийн хамт байгуулах төсөл”–ийн Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхийг шалгаруулах тендерыг зарлан, шалгаруулсан ба тендерт Канадын “Hatch” компани шалгарч АҮЯ-тай 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж ТЭЗҮ-ийг 2017 оны 09 дүгээр сард эцсийн тайлангаа хүлээлгэн өгсөн.<br>2. Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай” 273 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх зөвлөхийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2015 оны 11 сарын 18-ний өдөр зарлаж 2 шатны үнэлгээ хийж 2016 оны 03 сарын 11-ны өдөр “Экотон” ХХК компани шалгарсан ба 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр АҮЯ-тай гэрээ байгуулсан ба БОННҮ хийх ажил хийгдэж байна. Эцсийн тайланг 2018 оны 1 дүгээр улиралд хүлээн авна. 3. Мөн “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн БОННҮ-ний гүйцэтгэгчээр шалгарсан Монгол улсын “Green trends” ХХК-иудтай АҮЯамны ТНБД төслийн ажил гүйцэтгэх гурвалсан гэрээг 2016 оны 3-р сарын 23-ний өдөр байгуулсан ба “Green trends” ХХК нь төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж байгаа ба 2018 оны 2 дугаар улиралд тайланг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг БНХАУ-ын “Wuhuan engineering ” компани амжилттай хийж гүйцэтгэн УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | 3 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2015-02-17 №: 2015_36**<br><br>11 11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах. | “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхээр шалгарсан БНХАУ-ын "Wuhuan engineering" компани нь төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж 2017 оны 5 дугаар сард УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн ба төслийн БОННҮ-ны ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Green trends" ХХК нь 2018 оны 2 дугаар улиралд багтаан тайланг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 100 |
| 4 | 4 | **Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай**<br>2015-06-19<br><br>2.4 4/дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах. | “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар бүлгийн 7.3-д бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ гэж заасан ба нэгдүгээр үе шатны үнэлгээ 2020 онд хийгдэнэ.<br>**<u>ХЯНАЛТААС Х</u>** | /-/ |
| **4.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай**<br>2012-03-27 08/05<br>1 2011 оны УИХ-ын 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын 3 дугаар зүйлийн 4.6-д "Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн судалгаа хийх, бүтээгдэхүүн худалдан авах болон төслийн санхүүжилтэд Засгийн газраас баталгаа гаргах асуудлыг судлах" заалтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, технологийн сонгон шалгаруулалтын зарчмыг баримталж, төсөл хэрэгжүүлэгчид бүтээгдэхүүн худалдан авах баталгаа гаргах; | 2014 оны 1 дүгээр сард нүүрснээс шингэн түлш гаргах төслийг ХБНГУ-ын технологийг ашиглан хэрэгжүүлэх тухай ЗГ-ын 246 тоот тогтоолын дагуу төсөл хэрэгжүүлэгч “СИ ТИ ЭЛ Монголиа” 100% төрийн өмчит компанийг байгуулсан. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын ҮХААЯамны санаачилгаар, 2014 оны 04 дүгээр сард төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийн 49 хүртэл хувийг хувийн хэвшлийхэнд санал болгосон. Үүний дагуу ХБНГУ-ын “GME Energy Generation” ХХК төсөлд хамтран ажиллах санал ирүүлэн Төрийн өмчийн хороо болон “GME Energy generation” ХХК-ын хооронд хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулагдаж, 51% Төрийн өмчит “ГерМон газ” ХХК байгуулагдсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд зааснаар төсөл хөгжүүлэх шатанд “ГерМон газ” ХХК нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад итгэмжлэгдсэн төслийн үнэлгээ /project due diligence/ бүхий судалгааны ажил хийж, банкинд итгэмжлэгдсэн ТЭЗҮ /bankable Feasibility study/ боловсруулах үүрэг хүлээсний дагуу “ГерМон газ” ХХК нь ХБНГУ-ын нүүрс хийжүүлэх технологи болох “Lugri Fixed Bed Dry Bottom Process” болон нийлэг хий шингэрүүлэх “Fischer@Tropsch” технологиудыг ашиглан Шивээ-Овоогийн ордын нүүрснээс жилд 650 мянган тонн бензин, 84 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан. Гэвч Сангийн яамнаас төрөөс баталгаа гаргах асуудлыг зөвшөөрөөгүй тул хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй ба төслийн үйл ажиллагаа зогссон.<br>("Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого"-ын хэрэгжих хугацаа 2017 онд дууссан ба 2017-2027 онд "Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого"-ын баримт бичгийн төслийг боловсруулж байна.) | /-/ |
| | 2 | **Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай**<br>2012-03-27 08/05<br>2 Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх талаар аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлага, төслийн хэрэгжилтийн явц, холбогдох баримт бичгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах; | “MCS”, “МАК”, “Си Ти Эл” ХХК-иуд Нүүрсийг гүн боловсруулж, шингэн түлш үйлдвэрлэх ТЭЗҮ боловсруулж, Уул уурхайн яамны Эрдэс баялагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. “MCS” ХХК нь БНСУ-ын "Posco" компанитай энэ төсөл дээр хамтран ажиллах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр гэрээ хэлэлцээрийг хийж дуусгасан. “МАК Си Ти Эл” ХХК нь мөн санхүүжилтийн асуудлаар БНХАУ, Герман улсуудын хөрөнгө оруулагчидтай яриа хэлэлцээрийг хийсэн. “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК нь нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан ба санхүүгийн асуудал шийдэгдээгүй. ("Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого"-ын хэрэгжих хугацаа 2017 онд дууссан ба 2017-2027 онд "Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого"-ын баримт бичгийн төслийг боловсруулж байна.) | /-/ |
| 2 | 3 | | | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Газрын тос боловсруулах үйлдвэрийн тухай**<br>2014-03-17 14/06<br><br>1 Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах. | •Засгийн газраас 2017 оны 2-р сарын 17-ны “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай” 59 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. •ТӨБЗГ-ын 2017 оны 4-р сарын 4-ний өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийг байгуулан ажиллаж байна. •БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017 оны 06 дугаар сарын 06-ний өдөр ТЭЗҮ боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай уулзалт зохион байгуулж Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл болон холбогдох асуудлуудаар хэлэлцээр хийж нэгдсэн ойлголтод хүрсэн.<br>• Нарийвчилсан ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт тавих компани сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер явуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 7-р сарын 5-ны өдрийн А/113 тоот тушаалаар байгуулсан.<br>• Хөндлөнгийн хяналт тавих компани сонгон шалгаруулах нээлттэй тендерт шалгаруулалт зохион байгуулж Итали Улсын KT-Kinetics Technology SPA компани шалгалан захиалагчийн хяналтын гэрээг хийх хэлэлцээрийг зохион байгуулав.<br>• ТЭЗҮ-ийг боловсруулж буй Зөвлөх компани нь гэрээнд тусгасаны дагуу эхлэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14ний өдөр Захиалагчийн зүгээс тавьсан санал дүгнэлтийг тусган УУХЯ болон МГЛ Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д ирүүлсэн.<br>• Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсад хийгдэх инженер-геологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр “Престиж инженеринг” ХХК-г туслан гүйцэтгэгчээр сонгон газар дээр нь судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>• Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолойн трассыг тогтоох ажлын бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг 2017 оны 9 дүгээр сарын А/208 тоот тушаалаар байгуулсан. Энэ ажлын хүрээнд нарийвчилсан ТЭЗҮ-ний судалгаанд хамаарах Газрын тос боловсруулах үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трасс байрлуулах боломжтой газрын дэд бүтэц, инженер геологи, хүн амын суурьшил зэрэг нөхцөлийг харгалзан үзэж тогтоох судалгааны ажлыг хийж эхлүүлээд байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | • ТЭЗҮ-ийг 2018 оны 4 дүгээр сард хийж дуусган хүлээлгэн өгөх ба бүтээн байгуулалтын бэлтгэл ажил /дэд бүтэц/-ыг мөн онд багтаан эхлүүлж, 2022 оны 4 дүгээр улиралд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | 4 | "Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийн тухай<br>2014-08-18 32/14<br><br>1 БНХАУ-тай "нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхдээ Монгол Улс, БНХАУ-ын хоёр талын хувь оролцоо адил тэнцүү хэмжээтэй байх, талууд өөрт ногдох оролцооны хүрээнд хөрөнгө оруулагч, мэргэжлийн багийг татан оролцуулах эрх нээлттэй байх зарчмыг баримтлах. | Улсын Их Хурлын дарга БНХАУ-д 2014 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл”-ийн талаар талууд харилцан санал солилцсон. Жилд 500 сая метр куб хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2 жилийн хугацаанд байгуулж, Улаанбаатар хотыг хийгээр хангаж, хотын агаарын бохирдлыг бууруулах саналтай байгаагаа УИХ-ын дарга, БНХАУ-ын дарга Си Зиньпин болон Синопек корпорацийн удирдлагуудтай хийсэн уулзалтууд дээр илэрхийлсэн. Түүнчлэн жилд 16 тэрбум метр куб байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төслийг үргэлжлүүлэх, БНХАУ-тай хий худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг урьдчилан байгуулах тухай саналуудыг тус тус гаргасан. Байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр нь 5-8 жилд баригдах тул тус төслийн нэгжээс Улаанбаатар хотын гэр хорооллыг богино хугацаанд нүүрсний хийгээр хангаж, агаарын бохирдлыг бодитой бууруулах “Улаанбаатар хотын гэр хорооллыг хангах Нүүрсний хийн үйлдвэр” ба “Улаанбаатар хотын Хийн хангамж” төслийг санаачилж, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэжүүлэх хүсэлтийг гаргасан. БНХАУ-ын ЗГ-аас МУ-ын ЗГ-т олгох 500 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хавсралтад энэхүү төслийг оруулж, 162 сая ам.доллароор “ДЦС-2” ХК-ийг түшиглэн байгуулахаар 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газрын 135 тоот тогтоол гарсан. | 100 |
| | 5 | 2 Нүүрс боловсруулах химийн үйлдвэрүүдийг ажиллуулахад шаардлагатай дэд бүтэц болох хий болон ус дамжуулах хоолойг 100 хувь төрийн эзэмшилд байлгах зарчмыг баримтлах. | Төслийн нэгж БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3-7 дугаар сарын хооронд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хий дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос үйлдвэр барихаар санал болгосон 3 компанийн дунд сонгон шалгаруулалт зарлахаар холбогдох бэлтгэл ажлуудыг хангасан. МУ-ын ЗГ-аас БНХАУ-аас олгох хөнгөлттэй зээлийн санхүүжилтаар Хөшигтийн хөндийн хурдны замын төслийг хэрэгжүүлэх нь илүү чухал ач холбогдолтой гэж үзэн Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг “Улаанбаатар Хөшигтийн хөндийн хурдны зам барих төсөл”, “Туул гол дээгүүр яван өнгөрөх Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл”-д олгохоор шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6 | 3 Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газруудын зүгээс уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон татварын орчинг бүрдүүлж, бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хугацаа, ажиллах хүч зэрэг нөхцөл, шаардлагыг Монгол Улсын эрх ашиг, олон улсын жишигт нийцүүлэх зарчмыг баримталж ажиллах. | Төслийн нэгж 2014 онд БНХАУ-ын Синопек компанитай хамтын ажиллагааны хүрээнд Багануурын уурхай дээр 1-3 тэрбум шоо м3 синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих хувилбарыг хэлэлцэн, техник, эдийн засгийн судалгаа хийж тооцоолсны үндсэн дээр Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих үйлдвэр нь эдийн засгийн хувьд ашиггүй, Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш болохыг баталж, цаашид хэлэлцээрийг 2014 оны 8 дугаар сард хамтран гүйцэтгэж дууссан урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо м3 хүчин чадалтай нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих нөхцөлөөр үргэлжлүүлэхийг хүссэн. | 100 |
| | 7 | 4 Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотыг хийгээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг нэн тэргүүнд бүрдүүлэх эхний үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг шуурхай боловсруулах. | Төслийн нэгж 2014 онд БНХАУ-ын Синопек компанитай хамтын ажиллагааны хүрээнд Багануурын уурхай дээр 1-3 тэрбум шоо м3 синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих хувилбарыг хэлэлцэн, техник, эдийн засгийн судалгаа хийж тооцоолсны үндсэн дээр Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих үйлдвэр нь эдийн засгийн хувьд ашиггүй, Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш болохыг баталж, цаашид хэлэлцээрийг 2014 оны 8 дугаар сард хамтран гүйцэтгэж дууссан урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо м3 хүчин чадалтай нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих нөхцөлөөр үргэлжлүүлэхийг хүссэн. | 100 |
| | 8 | 5 Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх химийн үйлдвэрүүдийг байгуулах гэрээ хэлэлцээрийг хоёр талын холбогдох яамдын түвшинд байгуулах. | 2015 оны 11 сард Синопек корпорацийн удирлага солигдсоноор энэхүү төслийг үргэлжлүүлэх боломжгүй талаар БНХАУ-ын тал мэдэгдэж Засгийн газрын 2016 оны 2 сарын 26-ны өдрийн 131-р тушаалаар төслийн нэгжийг татан буулгасан. **ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| **4.е. Засгийн газрын тогтоол** | | | | |
| 1 | 1 | **Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай**<br>**2012-12-21 №: 2012_120**<br><br>50.2 Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж, хүдэр баяжуулах үйлдвэрт, цас борооны усыг ашиглах судалгаа болон усны нэмэлт эх үүсвэрийг тогтоох хайгуул хийж, зураг төсөл боловсруулна. | Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийг усан сангийн хамт барихаар төлөвлөсний дагуу 2011-2012 онд шинэ үйлдвэр баригдах талбайд инженер-геологи, хөрсний шинжилгээ судалгаанууд, нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр болон усан сан, далангийн газарт гадаргуугийн геофизикийн судалгаанууд хийгдсэн. 2013 оны 6 дугаар сараас эхлэн Усан сангийн газар шорооны ажлыг гүйцэтгэн ба энэхүү усан санг байгуулснаар үйлдвэрлэлийн усыг эргэлтэнд оруулж дахин ашиглах боломж бүрдсэн. Хүдэр баяжуулдаг үйлдвэрт цас, борооны усыг ашиглах, нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн хаягдлын далан барьж ашиглалтад оруулсан. Мөн Төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 1 сая тн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий нойтон соронзон баяжуулах үйлдвэр, хаягдлын байгууламжийн хамт 2014 оны 11-р сард ашиглалтанд оруулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 2 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай**<br>2014-10-25 352<br><br>2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчээр паркийн техник, эдийн засгийн үндэслэлийн эцсийн хувилбар, паркийн хөгжлийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэж, паркад байгуулах паркийн нэгжүүд, тэдгээрийг байгуулах аж ахуйн нэгж, нийт хөрөнгө оруулалт, түүний үндэслэл тооцоо, судалгааг эцэслэн гаргуулж, "Шинэ Азиа групп" ХХК-тай хамтран Засгийн газрын хуралдаанд 2015 оны 1 дүгээр сард багтаан танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид даалгасугай. | Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт "Баянговь нутаг" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах асуудлыг Засгийн Газрын 2015 оны 5 дугаар сарын 18 – ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 193 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. 2015 оны 8 дугаар сард Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ паркийн удирдлагатай гэрээ байгуулан ажилласан. 2015 оны 10 дугаар сард “Монгол-Хятадын анхдугаар экспо”-д хэлэлцэх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд “Баянговь нутаг” паркийн асуудлыг оруулсан бөгөөд экспогийн үеэр Тус паркийн удирдлага БНХАУ-ын Чинхуа групптэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.<br>Багануур дүүрэгт үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах асуудлыг Засгийн Газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 272 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөлийг олгосон. Аж үйлдвэрийн яам/хуучнаар/ нь паркийн удирдлагатай 2016 оны 6 дугаар сард гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн. "Шинэ Азиа групп" ХХК нь тусгай зөвшөөрөл авснаас хойш паркийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хийж хэрэгжүүлж буй ажлын тайланг ирүүлээгүй учир тусгай зөвшөөрлийг цуцлуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэсэн. | 70 |
| | 3 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2014-10-25 352<br><br>3 Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл авснаас хойш тодорхой хугацааны дараа техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын үндэслэл, судалгаа зэрэг хуульд заасан шаардлагыг танилцуулсны үндсэн дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх тухай үүрэг хүлээлгэх журмыг эрх зүйн үндэслэлийн хамт боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид үүрэг болгосугай. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлагыг тодорхой заасан байдаг.<br>Гэтэл Засгийн газрын энэхүү тогтоолын заалт нь ҮТП-ын эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх заалттай зөрчилдөж байгаа болно. Энэ талаар Хууль зүйн яамнаас амаар тодруулга авсан бөгөөд үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр журмаар зохицуулах боломжгүй гэсэн тайлбар өгсөн.<br>УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох сайд нараар батлуулсан. Мөн хуулийн төслийн талаар бүх яамдаас санал авч нэгтгэсэн ба Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | 4 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>2015-05-18 192<br><br>2 Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатарт, хэлэлцээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгасугай. | Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор "Зүүн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн концесс олгох /шалгаруулах/ үүрэг бүхий Ажлын хэсэг 2015 оны 6 дугаар сард Хөрөнгө оруулалтын газар дээр байгуулагдаж, концессийн сонгон шалгаруулалтыг 9 дүгээр сарын 1-нд зарласан. Уг уралдаант шалгаруулалтад материал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс хураангуй жагсаалт үүсгэж санал болгосон техник, технологийг үйлдвэрт нэвтэрч, туршигдсан байдлыг судлан үзэж үнэлэлт, дүгнэлт өгөх дэд ажлын хэсгүүдийг Аж үйлдвэрийн яаман дээр байгуулсан. Энэхүү дэд ажлын хэсгүүд ажиллан тус тусын санал, дүгнэлтийг боловсруулж Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын газар хураангуй жагсаалтад орсон компаниудаас санхүүгийн санал, бизнесийн төлөвлөгөөг авахаар ажиллаж байсан боловч тус хороо 2016 оны УИХ-ын сонгуулийн дараагаар татан буугдсан.<br>Энэхүү тогтоол Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дугаар тогтоолоор хүчингүй болсон. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 4 | 5 | **Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай**<br>2015-06-15<br><br>2 Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулан төр, хувийн хэвшлийн оролцооны хувь хэмжээг тогтоож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг сонгон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд тус тус даалгасугай. | "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын "Volant Industry" компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төсөл боловсруулах институт /ENFI/ "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник- эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулсан ба уг ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын 2016 оны "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай" 318 дугаар тогтоол батлуулсан. Дээрхи тогтоолоор "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нийт хувьцааны" 10 (арван) хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших тухай Аж үйлдвэрийн яамны саналыг зарчмын хувьд зөвшөөрч, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, мөн хөрөнгө оруулагчийг сонгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг тус яаманд даалгасан. (**Энэ тогтоол Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор хүчингүй болсон) ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | 6 | Жагсаалт батлах тухай<br>2015-08-17 №: 2015_337<br><br>2 Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд, Сангийн сайд нарт үүрэг болгосугай. | АҮЯ Засгийн газрын бүтцээр татан буугдсан тул тус заалтыг хяналтаас хасуулах. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 6 | 7 | **Тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2015-11-02 №: 2015_435<br><br>2 Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд нарт үүрэг болгосугай. /янжуур тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл/ | УУХҮЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 7 | 8 | Хөтөлбөр батлах тухай<br>2015-12-21 №: 2015_509<br><br>2 Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй. ХХААХҮЯ хариуцна. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | 9 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>**2016-01-04 №7**<br><br>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. | УУХҮЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | 10 | **Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-02-01<br><br>1 Хэнтий аймгийн Бор-Өндөр сумaнд жилд 2.3 сая тонн хүртэл газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай:<br>1/ төсөл хэрэгжүүлэх үндэсний компанийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалтыг 2016 оны I улиралд багтаан зохион байгуулах;<br>2/ уралдаант шалгаруулалтад шалгарсан хөрөнгө оруулагчтай улсын захиалгаар хийсэн газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр үйлдвэр барьж ашиглалтад оруулах, ажиллуулах талаар хэлэлцээ хийж, гэрээ байгуулах;<br>3/ газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих барилгын ажлыг энэ оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авах. | 1/ Засгийн газрын 75 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх Үндэсний компани(ууд)-ийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалт”-ыг Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаалаар зарлан явуулсан. Энэхүү уралдаант шалгаруулалтад үндэсний болон олон улсын компаниуд хамтарсан нийт 4 консорциум материал ирүүлсэн. Уралдаант шалгаруулалтад оролцсон эдгээр консорциумуудын материалыг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байсан боловч, уралдаант шалгаруулалтын оролцогч консорциумын гишүүн болох “Интер стандарт нефть" ХХК-иас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу шүүх 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 3792 дугаар захирамжаар захиргааны хэрэг үүсгэж, шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаалын биелэлтийг түтгэлзүүлэх шийдвэр гаргасан тул сонгон шалгаруулалт явагдаагүй болно.<br>Энэхүү тогтоол Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дугаар тогтоолоор хүчингүй болсон. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 11 | **Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-02-01<br><br>3 Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. | Энэхүү тогтоол Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дугаар тогтоолоор хүчингүй болсон. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| | 12 | **Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-02-01<br><br>4 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан үйлдвэрийг барих талбайн хэмжээ, газрын тос дамжуулах хоолой барих трассыг тогтоож, шаардагдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг боловсруулж зохих журмын дагуу Засгийн газарт оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. | Урьдчилсан ТЭЗҮ-ээр Чойр, Сайншанд, Бор-Өндөр, Чойбалсан зэрэг байршлууд дээр судалгаа хийж боловсруулах үйлдвэрийг газрын тосны ордын байршил, дэд бүтэц, түүхий тос болон бэлэн бүтээгдэхүүний логистик, зах зээлд ойр байх гэсэн үзүүлэлтээр харьцуулан судалж, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байгуулахаар сонгосон. Энэ ажлын хүрээнд Аж үйлдвэрийн сайд /хуучнаар/, Аж үйлдвэрийн яамны холбогдох нэгж Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд 2016 оны 02 дугаар сард албан томилолтоор ажиллан аймаг, орон нутгийн удирдлагуудтай уулзаж, үйлдвэр барихаар төлөвлөсөн 3-н газрыг урьдчилсан байдлаар сонгож эдгээр сонгосон талбай дээр давхардуулан газар олгохгүй байх тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгосон. Энэхүү тогтоол Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дугаар тогтоолоор хүчингүй болсон. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | 13 | **Зөвшөөрөл олгох тухай**<br>**2016-02-04 №88**<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зээлийг эргэн төлөх ажлыг ЗГ-ын 2016 оны 75 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгсугай. | УУХҮЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| 11 | 14 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>**2016-02-08 №96**<br><br>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. | УУХҮЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | 15 | **Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай**<br>**2017-02-15 №59**<br><br>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банктай хэлэлцэн тохиролцохыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд, төслийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж болон холбогдох сайд нарт даалгасугай. | ТӨБЗГ-ын 2017 оны 4-р сарын 4-ни өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийг байгуулан ажиллаж байна. БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэсэлэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ний ... тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017 оны 06 дугаар сарын 06-ний өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай эхний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл болон холбогдох асуудлуудаар хэлэлцээр хийж байна. Улмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэхтхэг Улсын Экспорт-импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн зориулалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын байнгын хороодоор зөвшилцсөний дараа ажлын журмаар Засгийн газрын зүгээс шийдвэр гаргахаар ЗГ тэмдэглэл гарсан. ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | 16 | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2017-03-15 №: 2017_88<br><br>2 Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай. | УУХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна. Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компани "Таван Лекс" ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан. Улмаар 2018 онд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх, үйлдвэр байгуулах бэлтгэл ажлуудыг эхлүүлэх юм. | 30 |
| | 17 | **Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2017-03-15**<br><br>3 Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай. | УУХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна. Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компаниар "Таван Лекс" ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан. Улмаар 2018 онд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцох юм. | 30 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | 18 | **Төрийн өмчит компани байгуулах тухай**<br>2017-03-20<br><br>2 “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, судалгаанд тулгуурлан энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан компанийг үүсгэн байгуулах ажиллагаа болон бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн санхүүжилт, холбогдох бусад зардалд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд тус тус даалгасугай | Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд :<br>1. Ерөнхий Сайдын 2017 оны 3-р сарын 30-ны өдрийн 60 дугаар захирамжаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулах Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осороор ахлуулан байгуулсан.<br>2. ТӨБЗГ-ын 2017 оны 4-р сарын 4-ний өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслий өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийг байгуулсан. | 100 |
| 15 | 19 | Үндэсний хөтөлбөр батлах тухай /Хөгжлийн зам/<br>2017-05-10 №: 2017_142<br><br>3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбартаа хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Хөтөлбөрийн 3.7.1. " Хэрлэн тооно" төслийг хэрэгжүүлэх, хүнд үйлдвэрүүдийн үйл ажиллагааны усны хэрэгцээг хангах урсацын тохируулга бүхий усан цогцолбор байгуулах" заалтын хүрээнд "Төслийн техникийн даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулах зорилго бүхий хоёр яам /БОАЖЯ/-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл”-ийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2020 тоот албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтыг 2018 онд зохион байгуулах ажлын үндсэн хариуцагчаар БОАЖЯ ажиллаж байгаа болно. Мөн хөтөлбөрийн 3.7.3 Багануурын нүүрсний ордыг түшиглэн нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн барилгын ажлыг дуусгах, 3.7.4 Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг 2017-2021 онд дуусгах заалтын хүрээнд тус төслүүдийн үйл ажиллагааг хангах Төслийн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган ажиллаж байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 16 | 20 | **Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай**<br>**2017-08-17 №232**<br><br>1. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх тухай" 232 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус төслийн техникийн даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулах зорилго бүхий хоёр яам /БОАЖЯ/-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2020 тоот албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажлын үндсэн хариуцагчаар БОАЖЯ ажиллаж байгаа болно. | 30 |
| 17 | 21 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2017-08-23 №: 2017_242<br><br>2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулж, хууль тогтоомж болон гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 242 дугаар тогтоолоор паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон "Дархан үйлдвэрлэл, технологийн парк" ХХК, "Эрдэнэт технопарк" ХХК-д УУХҮ-ийн сайдын 2017 оны А/200 дугаар тушаалаар паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. Мөн УУХҮЯ нь тус паркийн удирдлагуудтай 2017.10.09-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд паркийн удирдлагууд гэрээний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2017.11.30-ны өдөр тус паркийн удирдлагууд УУХҮ-ийн сайд Б.Сумъяабазарт гэрээний дагуу хийж хэрэгжүүлж байгаа ажлынхаа талаар тайлагнав. | 100 |
| **4.ё. Ерөнхий сайдын захирамж** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай ”Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах**<br>2016-11-22 №: 2016_113<br><br>2 Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | Засгийн газрын 2016 оны 107 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг байгуулан ажиллаж байна. Монгол улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 113 тоот захирамжаар байгуулагдсан “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг УУХҮЯ-ны хурлын танхимд 2017 оны 01 дүгээр сарын 25 өдрийн 11 цагт Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Баатарсүх даргалан явуулсан. Энэхүү хуралдаанаар төслийн нэгжийн танилцуулга хийгдэн дараах асуудлуудыг шийдвэрлэхээр болсон. Үүнд:<br>1. ЭХЯамны түгээх шугам сүлжээний журам, стандартаа гаргах ажлын хэсэгт ХҮБГ-аас мэргэжилтэн ажиллуулах<br>2. БОАЖЯам, ННБХҮ үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ний хүрээнд хийгдсэн байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээнд холбогдолтой дүгнэлтийг гаргах.<br>3. Төслийн нэгж, “Эрдэнэс Монгол”ХХК болон Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, судалгааг хийх, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, Багануурын уурхайн удирдлага мэргэжилтнүүдэд төслөө танилцуулах.<br>4. Төслийн нэгж, Төв аймгийн Баяндэлгэр суманд төслийн байршлын газрын асуудлаар 2017 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн дотор аймгийн удирдлагуудтай хамтран ажиллах.<br>Энэхүү төсөл хэрэгжүүлэх нэгж нь Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, хий дамжуулах хоолойн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллах бөгөөд үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн 2017 оны 04 дүгээр сард хүлээн аван УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан.<br>Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайланг 2018 оны эхний хагас жилд багтаан зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компаниас хүлээн авна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 2 | **Ажлын хэсэг байгуулах тухай ”Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах**<br>2016-11-22 №114<br><br>2 Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | Ерөнхий сайдын захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан ажиллаж "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийг Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгуулах, үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр эзэмших тухай санал, дүгнэлт боловсруулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлсэн. (Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоол) | 100 |
| **4.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | |
| 1 | 1 | **2015 оны 02 дугаар сарын 12-ний өдөр 10 дүгээр тэмдэглэл**<br>2015-02-12<br><br>II. 2. Эдийн засгийн түншлэлийн тухай Энэхүү хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлсны дараа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт даалгав. | Чиг үүргийн дагуу ХХААХҮЯ хариуцан ажиллана. **ХЯНАЛТААС ХАСУУЛАХ** | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 2 | **2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл**<br>2016-03-28<br><br>I Дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдаанаас учирч болох хохирлоос хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг Хууль зүйн сайдтай хамтран баталж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан хуулийн төслийн нэрийг оновчтой болгох зэрэг саналыг тусган хуулийн төслийг боловсруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. | Чиг үүргийн дагуу ХХААХҮЯ хариуцан ажиллана. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ | /-/ |
| 3 | 3 | **2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл**<br>**2016-04-04**<br><br>XYIII. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүйн сайдтай хамтран боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. | Чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллана. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ | /-/ |
| 4 | 4 | **2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2016-04-18** “XY. “Хөшигийн хөндий чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд үзэл баримтлалыг батлахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгав. | “Хөшигийн хөндий чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцээд үзэл баримтлалыг батлан УИХ-аар хэлэлцүүлэхийг Сангийн сайд, Хууль зүйн сайд, Аж үйлдвэрийн сайд нарт даалгасан. Хууль батлагдаагүй байна. | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | 5 | **2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 29 дүгээр тэмдэглэл**<br>2016-05-23<br>XXXI.3. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган уг асуудлаар тогтоолын төсөл боловсруулж, зохих журмын дагуу холбогдох байгууллагаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. | Уг төслийн хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгчийг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Хөрөнгө оруулагчид тавигдах шаардлагыг Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газрын саналыг тусган боловсруулж байна. Улмаар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг тохиролцох юм. | 70 |
| 6 | 6 | **2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 33 дугаар тэмдэглэл**<br>**2016-06-13**<br>YI. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай” Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд дахин судалж үзсэний үндсэн дээр саналаа Засгийн газарт оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. | Тус тогтоолын 2 дугаар хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй, Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж АҮЯ татан буугдсан. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ | /-/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | 7 | **2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>2016-11-30<br>XII.2 Үйлдвэржилтийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг яаралтай боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгав. | "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг Засгийн газрын 2015 оны "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай" 62 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| 8 | 8 | 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 36 дугаар тэмдэглэл<br>2015-06-15 №: 2015_36<br><br>XXYI.2. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр, цех байгуулах талаар өмнө нь гаргасан шийдвэрүүдийг өөрчлөх болсон шалтгаан, үйлдвэрийн байршлыг шинэчлэн тогтоосны ач холбогдлыг нийтэд сурталчлан танилцуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. | Аж үйлдвэрийн яамнаас Засгийн газрын 2015 оны "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 247 дугаар тогтоол батлуулж, үйлдвэрийг Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байгуулахаар байршилыг тогтоосон. "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2015 оны 247 дугаар тогтоол, "Газрын тос боловсруулах үйлдвэр барих тухай" Засгийн газрын 2016 оны 75 дугаар тогтоолын хэрэгжилтыг эрчимжүүлэх, нутгийн удирдлагууд, иргэдийн төлөөлөлд төслийн ач холбогдлыг танилцуулах, хамтран ажиллах зорилгоор Аж үйлддвэрийн сайд Д.Эрдэнэбат тэргүүтэй ажлын хэсэг Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд зөвлөлдөх, таниулах уулзалтыг 2016 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд зохион байгуулсан. Засгийн газрын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул хяналтаас хасах саналтай. **ХЯНАЛТААС ХАСАХ** | /-/ |
| **ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ** | | | | |
| **5.а. Монгол Улсын хууль** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**<br>2009-07-16<br><br>7. “6.Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах, цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх, цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээнд хамаарахгүй.<br>7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.” | БХЗГ | 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ЦЭТХхуулийн нэмэлт өөрчлөлт, 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын 72 дугаар тогтоолд заасанаар ЦЭК-ын эрх үүргийн талаар:<br>- “цөмийн материалын тооллого, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах,<br>- “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах”,<br>- “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослын хор уршгийг арилгах талаар яаралтай авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх” гэж заасан байдаг. Иймд эрхлэх чиг үүргийн дагуу ЦЭК-ын ажлын алба эдгээр асуудлыг хариуцан ажиллаж байна. ЦЭК-ын ажлын албанаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд эдгээр дүрэм журмуудыг 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулж ажилласан. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |
| **5.б. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | **“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>2015-01-23<br><br>2 2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр ашиглах бодлого баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай. | БХЗГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд Эрдэнэтийн овооны зэс, Гацууртын алтны үндсэн ордын талбайн хил заагийг урьдчилан тогтоож газар дээр нь очиж ажилласан. Засгийн газрын 2017 оны 109 дүгээр тогтоолоор Гацууртын алтны үндсэн орд, Засгийн газрын 2017 оны 255 дугаар тогтоолоор Эрдэнэтийн овооны зэс, молибдений ордын талбайн хил заагийг тус тус тогтоосон. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| **5.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 1 | 1 | | БХЗГ | | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай** 2016-01-12<br><br>Нэг.1/ Нэг. Уул уурхай, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай.<br>1/Уул уурхайгаас ангид байх газруудыг тодорхойлон хамгаалах, экологийн бүс нутгийн үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх; | | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас тодорхой санал ирүүлээгүй байна. /Үнэлэх боломжгүй/ **ХААХ САНАЛТАЙ** | |
| | 2 | Нэг.2/ Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө тооцох хэлбэр, хэмжээг шинэчлэх, эрсдлийг бүрэн даахуйц болгох, | | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас тодорхой санал ирүүлээгүй байна. /Үнэлэх боломжгүй/ **ХААХ САНАЛТАЙ** | /-/ |
| | 3 | Нэг.3/ Ашигт малтмалыг олборлох, боловсруулахад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үндэсний стандартыг бий болгож мөрдүүлэх, уурхайн хаалтыг европын холбоо болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэх, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүх уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үнэлэх арга, аргачлалыг батлан мөрдүүлэх; | | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас тодорхой санал ирүүлээгүй байна. /Үнэлэх боломжгүй/ **ХААХ САНАЛТАЙ** | /-/ |
| | 4 | Нэг.4/ Бичил уурхайд тавигдах шаардлага, хяналт, хариуцлагыг чангатгах; | | "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан. Шинэ журмаар бичил уурхайд тавигдах шаардлага, хяналт, хариуцлагын тогтолцоог аймаг, нийслэлийн Засаг дарга нэгдсэн удирдлагаар хангах, хяналт хийхээр тусгаж өгсөн. | 100 |
| | 5 | Нэг.5/ Хууль зөрчсөн болон хууль хэрэгжүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх. | | Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт УИХ-аар батлагдсанаар хариуцлага, торгуулийн хэмжээ өөрчлөгдсөн. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| | 6 | Хоёр. Тогтоолын биелэлтийг 2016 оны хаврын чуулганы хугацаанд багтаан зохион байгуулж, Өргөдлийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай. | | Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан тухайн асуудал танилцуулагдаагүй. **ХАСАХ САНАЛТАЙ** | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 7 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2014-12-17 №: ӨБХ-09<br>1.1-1.4 УУЯ, БОНХЯ-ны хариуцах заалт | ХШҮДАГ | Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт орших байгалийн үзэсгэлэнт, тахилгатай Хутаг уулын орчимд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Галакси майнинг" ХХК нь тус сумын удирдлага болон иргэдтэй ойлголцолд хүрсэнээр уг асуудал шийдэгдсэн. Хасуулах саналтай. | 100 |
| 3 | 8 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2015-02-18 №: 2015-01-05**<br>03 Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтааж танилцуулах | БХЗГ | Биелэлтийг тус оны хаврын чуулганд багтаан танилцуулсан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| 4 | 9 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2016-11-23 №03<br>10 Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэгт заасан усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хамрах хүрээг өргөтгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх | БХЗГ | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах, бүрэн эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх, дээр дурьдагдсан зөрчлүүдийг нэг мөр шийдэх үүднээс “Ашигт малтмалын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд энэхүү хуулийн зохицуулалтыг хийх хүртэл түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зогсоосон. Холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж байна. | 100 |
| | 10 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2016-11-23 №: 2016_03<br>Нэг. 3/ Туул голын сав газар, түүний ойр орчимд элс, хайрга олборлохыг зогсоох | БХЗГ | Заамар сумын нутаг дэвсгэрт, Туул голын сав газрын дагуу 19 хайгуулын тусгай зөвшөөрөл “Ашигт малтмалын тухай” хуулийн хүрээнд хүчин төгөлдөр байна. Эдгээрээс 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 онд хайгуулын ажилд нийт дүнгээрээ 2,9 тэрбум төгрөг зарцуулсан байна.<br>Мөн тус сумын нутагт олгогдсон алтны 84 хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас 2016 онд 42 тусгай зөвшөөрөл эзэмшигч уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас 2017 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 38 тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт явуулсан ба 28 тусгай зөвшөөрлийн талбай нь урт нэртэй хуулийн хамгаалалтын бүстэй хэсэгчилэн давхцалтай байгаа тул давхцалгүй хэсэгт үйл ажиллагаа явуулжээ.<br>Үлдсэн ашиглалтын тусгай зөвшөөрөлүүд нь олборлолтоор | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ордын нөөц дууссан, хөрөнгө оруулалт байхгүйн улмаас зогссон болон хуулийн хүрээнд хамгаалалтын бүсүүдтэй давхцалтай гэх мэт шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулаагүй байна. | |
| | 11 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2016-11-23 №: 2016_03<br><br>Нэг. 9/ Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж, Туул голын энгийн хамгаалалтын бүсэд олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 11, ашиглалтын 39 тусгай зөвшөөрлийг цуцлах, 116.9 га талбайд нөхөн сэргээлт хийлгэх | БХЗГ | Туул голын энгийн хамгаалалтын бүсэд олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын газраас олгосон боловч Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга.... тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын дүгнэлт гаргасан...үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцална” гэж заасан байх тул дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлах асуудал нь аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарч байна. | 100 |
| | 12 | Хоёр. Тогтоолын биелэлтийн явцыг 2016 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Д.Оюунхорол/, Барилга, хот байгуулалтын яам /Г.Мөнхбаяр/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Ц.Дашдорж/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /П.Сэргэлэн/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н Цагаанхүү/, нийслэлийн Засаг дарга /С.Батболд/-д тус тус даалгасугай | БХЗГ | Тогтоолын биелэлтийг Өргөдлийн байнгын хороонд хүргүүлж, 2017 оны 2 сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. | 70 |
| 5 | 13 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2016-12-21 №05<br><br>1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 17.2.9, 54.11, 57.2, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.9, 39.3, 39.7 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж, хяналтыг сайжруулах, хууль<br>тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, холбогдох журам, стандартыг гаргах | БХЗГ | Тогтоолын биелэлтийг ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгайлсан санал ирүүлээгүй тухай 2017.11.14-ны өдрийн 01/ дугаар албан бичгээр хүргүүлсэн. /ХЯНАЛТААС ХАСАХ/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 14 | 11 Тогтоолын биелэлтийн явцыг 2017 оны эхний хагас жилд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчалын яам /Д.Оюунхорол/, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам /Ц.Дашдорж/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүүl-т тус тус даалгасугай | | Тогтоолын биелэлтийг эцсийн байдлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолын хэрэгжилтийн талаарх Нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, холбогдох мэдээллийг өгсөн. . **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| | 15 | 3 Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж, байгаль орчны нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд шалгалт хийж, эвдрэлд орсон газрыг холбогдох этгээдээр нөхөн сэргээлгэх, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж, хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцож, тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авах, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээх нэрийн дор ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр орон нутгийн удирдлагуудад чиглэл өгч, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох; | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| | 16 | 4 Орхон голын бохирдлын асуудалд онцгой анхаарал хандуулж, голын эхэнд уул уурхайн үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжүүдийн технологийн горимд тавих хяналтыг сайжруулах, | | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл орж ажилласан бөгөөд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажилласан бөгөөд энэ тухай саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| | 17 | 9 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх | | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлуулсан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| **5.г. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах тухай** 2007-05-24 1 “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харъяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай. | ТЗУГ | Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Төрийн нарийн бичгийн даргын А/77 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан 2017 оны 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Нийслэлийн Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгууллаа. Тус “Нээлттэй хаалганы өдөрлөг”–т хамтран ажиллахаар 25 байгууллага 28 асарт хоёр өдрийн турш олон нийтэд зориулсан танилцуулга, сурталчилгаа хийж оролцсон. Өдөрлөгийн үйл ажиллагааны нэг гол хэсэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр салбарын үйл ажиллагааг сурталчлах ажил байсан бөгөөд энэ ажлын хүрээнд 17 хэвлэл, мэдээллийн байгууллагыг урьж, тус бүр мэдээ, ярилцлага, сурвалжилга, фото сурвалжилга гаргасан болно. | 100 |
| 2 | 2 | Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай 2017-06-16 №136<br><br>1. 1. Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг иргэдэд уриалсугай. 2. Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг төрийн захиргаа, нутгийн өөрөө уидирдах болон холбогдох бусад байгууллагад даалгасугай. | ТЗУГ | МУ-ын ерөнхийлөгчийн 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн зарлигийн дагуу Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг яамны нийт албан хаагчдад уриалан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 |
| **5.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл** | | | | | |
| 1 | 1 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай** 2017-07-19 19/5 1. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, тероризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | ТЗУГ ХХ | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон уг хуультай холбогдон гарсан бусад дүрэм, журам, зааврыг сонгон шалгаруулалтын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 |
| **5.е. Засгийн газрын тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө батлах тухай,** 2011.05.18 №159 2.Эрхлэх ажлынхаа хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн 2014 онд биелэлтийг нь гаргахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт... даалгасугай. | ТЗУГ | НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө дагуу Уул уурхайн салбарт хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний төслийг бэлтгэж холбогдох газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| 2 | 2 | **Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай** 2015-03-11 №94 3 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд | БХЗГ | Энэхүү тогтоолын зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэхээр алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгөнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 256,0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкуудаар дамжуулан он дуустал олгоно. Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Уул уурхайн сайдын 2015 оны А138/273/206 тоот хамтарсан тушаалаар Алт худалдан авах урьдчилгаа | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай:<br>3.1. гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулах;<br>3.2. усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалттай бүсийн хилийн заагийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай тогтоох;<br>3.3. ашигт малтмалын нөөцийн тодотгол, техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг бүртгэх, хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах;<br>3.4. "Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэн ажиллаж байгаа шороон ордыг ашиглах боломжийг судалж шийдвэрлэх. | | санхүүжилтийн арга хэмжээ батлагдсан бөгөөд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2. Зээл хүссэн ААН-үүдийн жагсаалтыг эхний ээлжинд Монгол банкинд хүргүүлсэн. "Алт үйлдвэрлэгчдийн холбоо"-оор дамжуулан зээлийн хүсэлтүүдийг хүлээн авч судалгааг хийсэн. Монгол банк, Сангийн яамны зүгээс тохирсон схемийн дагуу санхүүжилтийг арилжааны банкинд олгоогүй байна. /Биелэлт-60%/<br>3.1. ЗГ-ын 2015.03.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор "Журам, гэрээний загвар"-ыг батуулсан. Мөн 235 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 04 сарын 21-ны өдрийн А-185 тоот тушаалаар Хилийн заагын тодорхойлолт гаргах, маргаан шийдвэрлэх комисс томилогдон ажиллаж байна. 6 сард багтаан ЗГ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Газар дээр нь томилолтоор ажилласан. Мөн УУ-н Сайд, БОНХАЖ-ын Сайд нарын 97/А-227 тоот тушаалаар хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байна.<br>5. БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 04 сарын 21-ны өдрийн А-185 тоот тушаалаар Хилийн заагын тодорхойлолт гаргах, маргаан шийдвэрлэх комисс томилогдон ажиллаж байна. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг хуульд заасан 200м-ын хилийг БОНХАЖЯам 1:100 000 масштабтай газрын зургаас татан буулгасан байна. Дэглэмийг мөрдөн ажиллаж байна.<br>3.3. Шуурхайлах зорилгоор АМГ-ын дотоод журамд өөрчлөлт оруулж, тойрох хуудас, хянах албан тушаалтны тоог цөөрүүлж, ирүүлсэн ААН-үүдийн бичиг баримтыг шуурхай хянан баталгаажуулж байна.<br>7.Уг тогтоолд хамрагдсан "Монполимет" ХХК-ийн Тосонгийн гольдролын алтны шороон орд, "Их тохойрол" ХХК-ийн алтны ордыг ашиглалтанд оруулах ажлыг эхлүүлэхээр урт нэртэй хууль болон холбогдох ЗГ-ын тогтоолуудын үйлчлэх хүрээнээс гаргах асуудлаар "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2015 оны 130 дугаар тогтоол батлуулсан.Тогтоолыг хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3 | **Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2015-03-11 №94<br><br>4 Улсын хилийн зурвас болон тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай зарим ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судалж, саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт 2015 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нарт даалгасугай. | БХЗГ | Дээрх тогтоолын дагуу Батлан хамгаалахын, Уул уурхайн сайдын хамтарсан тушаалаар Ашигт малтмалын ордыг эзэмших, ашиглах, хилийн зурвас, тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн зарим алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр тодорхой санал дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Хамтарсан ажлын хэсэг Уул уурхайн яаман дээр 3 удаа уулзаж санал солилцож ажилсан. Ажлын хэсгээс Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамаарах баттай, бодит боломжтой нөөцтэй алтны орд 51 илрэлүүдийг баттай, бодитой нөөцөөр нь ангилсан. Мөн Монгол Улсын хилийн дагуу 100 км бүсэд тогтоогдсон алтны ордуудын мэдээллийг АМГ-с гаргуулсан. | 100 |
| 3 | 4 | **Албан татварыг хэсэгчлэн төлүүлэх тухай**<br>2015-05-18 №190<br><br>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа “Монголын алт” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай. | УУБГ | Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа "Монголын алт" ХХК-тай байгуулах гурвалсан гэрээний төсөл одоогоор тус яаманд ирээгүй байна. УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор тус ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон “Монголын алт” ХХК, “Эрдэнэс Цагаансуварга” ХХК-ийн хооронд 2015 оны 11 сард тус ордыг түшиглэн байгуулах Баяжуулах үйлдвэрийн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. /ХБНГУ-аас “Монголын алт” ХХК-д олгох зээлийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргасан/ | 70 |
| 4 | 5 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2015-07-07  №: 2015_289<br><br>4 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. | БХЗГ | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 6 | **Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>2015-07-20 №302<br><br>2 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. | БХЗГ | Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь БОАЖЯ-ны эрх үүрэгт хамаарах бөгөөд тогтоолд өөрчлөлт орсон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн. <u>**ХАСАХ САНАЛТАЙ**</u> | 100 |
| 6 | 7 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2016-03-14 №: 2016_155<br><br>2 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. | БХЗГ | Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь БОАЖЯ-ны эрх үүрэгт хамаарах бөгөөд тогтоолд өөрчлөлт орсон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн. <u>**ХАСАХ САНАЛТАЙ**</u> | 100 |
| 7 | 8 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай<br>2016-10-26 №: 2016_121<br><br>3. Төлөвлөгөөнд тусгасан томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2017 онд багтаан эцэслэн боловсруулж 2018 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ш.Дашдорж, Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн засаг дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсайхан нарт даалгасугай. | ХШҮДАГ | 1. Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор УУХҮС-ын 2017 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлах тухай" А/22 дугаар тушаалыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. 2. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхээр шалгарсан БНХАУ-ын "Wuhuan engineering" компани нь төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж 2017 оны 5 дугаар сард УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн ба төслийн БОННҮ-ны ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Green trends" ХХК нь 2018 оны 2 дугаар улиралд багтаан тайланг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 9 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-01-04 №6<br><br>4 Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай. | ТЗУГ ГХАХ | Хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд зориулан Монгол Улсыг сурталчлах Mongolia@PDAC-2017 форумыг 2017 оны 03 дугаар сарын 5-ны өдөр Канад Улсын Торонто хотноо амжилттай зохион байгуулав. Тус форумд гадаад, дотоодын нийт 250 гаруй төлөөлөгчид оролцсон бөгөөд форумын үеэр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин, эдийн засаг, нийгмийн талаар төрийн төлөөлөгчид болон хувийн хэвшлийнхэн мэдээлэл өгч, ардын урлагийн "Хөсөгтөн" хамтлагийн тоглолтыг толилуулав. -Австрали Улсын Засгийн газрын санхүүжилттэй AMEP төсөлтэй хамтран Австрали Улсын Мелбурн хотноо 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд IMARC-2017 арга хэмжээг зохион байгуулж, УИХ, ЗГ, УУХҮЯ, АМГТГ болон бусад хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулав. - Монгол-Хятадын 2 дахь удаагийн экспо арга хэмжээг Монгол Улсын ХХААХҮЯ, Үндэсний хөгжлийн газартай хамтран 2017 оны 09 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулж, салбарын томоохон компаниудын оролцох оролцоог хангав. | 100 |
| 9 | 10 | Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай<br>2017-02-08 №: 2017_47<br>2 “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зохих журмын дагуу батлуулан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат нарт, хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | ХШҮДАГ | “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд **журмын** төсөлд нийт газруудаас саналыг авч холбогдох газарт хүргүүлсэн бөгөөд ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан. Ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг хийж гүйцэтгэж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 11 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2017-03-15 №: 2017_83<br><br>2 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | БХЗГ | Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь БОАЖЯ-ны эрх үүрэгт хамаарах бөгөөд тогтоолд өөрчлөлт орсон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн.. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| 11 | 12 | **Журам батлах тухай**<br>2017-04-12 №111<br><br>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | ТЗУГ ХХ | "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"-ын дагуу тус яам нь Төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад албан бичгийг цахимжуулан хүлээн авах, бүртгэх, явуулах, дамжуулах, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, цахим баримт бичгийг ангилан төрөлжүүлэх, албан хэрэг бүрдүүлэх, хадгалахдаа Able програмыг ашиглан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна.<br>Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх үйл ажиллагаандаа Архивын тухай хууль, Монгол хэлний тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 |
| 12 | 13 | **Журам батлах тухай (түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам)**<br>**2014-07-09 №: 2014_222**<br><br>2 Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | БХЗГ | Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг Зам, тээврийн яамнаас боловсруулж, батлуулсан бөгөөд журмыг мөрдөж ажиллаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 14 | **Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай**<br>**2017-01-25 №: 2017_27**<br><br>3 Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах энэ тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан орон тооны бус комисс, хороо, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн, Засгийн газрын агентлагийн даргатай тохиролцсоны үндсэн дээр шинэчлэн баталж ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | БХЗГ | ЗГ-ын 2017 оны "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" 27 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтад заасан комисс, хороо, ажлын хэсгийг УУХҮСайд даргалахаар тусгаагүй байна. **ХААХ САНАЛТАЙ** | 100 |
| | 15 | **Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай**<br>**2017-01-25 №: 2017_27**<br><br>4 Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | БХЗГ | Тус тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүн 2017 онд хуралдаагүй болно. 2 дугаар хавсралтад заасан Стандартын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд БХЗГ-ын дарга томилогдон ажилласан. Стандартын үндэсний зөвлөл нь сар бүр хуралддаг бөгөөд тухай бүрийн хуралдаанд оролцож санал өгсөн. Стандартчиллын төлөвлөгөөт ажилд тусгагдсан “Улсын стандарт хянаж шинэчлэх” зорилготой 9 нэрийн цуврал стандартууд, “Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэд стандартыг орчуулж үндэсний болгох” зорилготой 9 нэр төрлийн, нийт 18 стандартын төслүүд ирүүлснийг судлан танилцаж, холбогдох шүүмжийг хийж, Техникийн хорооны хуралдаанд оролцон санал дүгнэлтээ танилцуулсан. | 100 |
| 14 | 16 | **Хөрс хамгаалах өдөртэй болох тухай**<br>2017-05-24 №149<br><br>3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | БХЗГ | 2018 оны 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг “Хөрс хамгаалах үндэсний өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд АМГТГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 17 | **Журам батлах тухай**<br>**2017-05-24 №: 2017_151**<br><br>2. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг хамтран боловсруулж, батлан мөрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | БХЗГ | Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн төслийг боловсруулж, 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/115-А/123 тоот тушаалаар дүрмийг баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 3775 дугаарт бүртгүүлсэн. | 100 |
| 15 | 18 | **Журам батлах тухай**<br>**2017-05-24 №: 2017_151**<br><br>3. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | БХЗГ | Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал, төлөвлөгөөний загварыг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/226-А/182 тоот тушаалаар баталсан. | 100 |
| 15 | 19 | **Журам батлах тухай**<br>**2017-05-24 №: 2017_151**<br><br>4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжиййг сурталчилан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | БХЗГ | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт 10 чиглэлийн дагуу орон нутгийн удирдлагатай уулзалт зохион байгуулж ажилласан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | 20 | **Журам батлах тухай**<br>**2017-06-07 №160**<br><br>2. Гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, маргаан үүсэх болон маргааныг шийдвэрлэх шатанд энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга нарт болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагад тус тус даалгаж, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын дарга нарт зөвлөмж болгосугай. | ТЗУГ ГХАХ, ХХ | Захиргааны ерөнхий хууль батлагдаж, Гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, маргаан үүсэх болон маргааныг шийдвэрлэх тухай журам батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулагч төдийгүй дотоодын хөрөнгө оруулагчийн эрх ашиг, сонирхол зөрчигдсөн асуудалд сонсгох ажиллагаа явуулах, эрх ашиг, сонирхол нь зөрчигдсөн талаар холбогдох тайлбарыг авах ажиллагааг тухай бүр явуулж байна. | 100 |
| 17 | 21 | **Төв, суурин газрын 2017 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2017-06-28 №187<br><br>1. Түлш, эрчим хүч, уул уурхай, газрын тос болон боловсрол, эрүүл мэнд, зам, тээвэр, харилцаа холбоо, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | БХЗГ | 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг батлан, яамны УУБГ, ТБГ-тай хамтран амжилттай хэрэгжүүлж байна. "Багануур" ХК," "Шивээ-Овоо" ХК-уудад авахад бэлэн нүүрсний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах талаар үүрэг өгч, мэдээг тогтмол авч ажиллаж байна. “Багануур” ХК 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар сард 2.97 сая тн нүүрс олборлохоос 3.06 сая тн нүүрс олборлож, төлөвлөгөөний биелэлт 100.2 хувьтай байна. Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 67 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 99 хувьтай байна. Тус компани Дулааны 4-р цахилгаан станц /ДЦС-4/, ДЦС-3, ДЦС-2, Дарханы ДЦС, Багануурын ДС, Амгалангийн ДС-ын эрчим хүчний нүүрсний хэрэглээг хангаж байна. Эдгээр Дулаан болон цахилгааны станцуудын гаднах талбай дахь нүүрсний нөөцийг дурьдвал: /ДЦС-4/ – 19 хоног, /ДЦС-3/ – 16 хоног, /ДЦС-2/ – 21 хоног, /ДДЦС/ – 22 хоногийн тус тус нөөцтэй байна. “Шивээ-Овоо” ХК 2017 оны эхний 10 сард 1.59 сая тн нүүрс олборлохоос 1.57 сая тн нүүрс нүүрс олборлон 1.5 сая тн нүүрс борлуулсан байна. Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 42 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 73 хувьтай байна. Тус компани ДЦС-4, Налайхын ДС, Бор-Өндөрийн УБҮ, УБТЗ, Дорноговь ДС, Говьсүмбэр ДС болон бусад хэрэглэгчдийг эрчим хүчний нүүрсээр хангаж байна. Мөн Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 297 дугаар тогтоолоор 2018 онд газрын тосны | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг тогтоож батлуулсан. | |
| 18 | 22 | **Агаарын хэт халалт, хуурайшилттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2017-07-16 №205<br><br>1. ж/ ой, хээрийн түймрийн голомтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын ус зөөвөрлөх том оврын машин, техник хэрэгслийг дайчлах талаар холбогдох арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид; | БХЗГ | Ой, хээрийн түймрийн голомтын бүсэд (Сэлэнгэ, Төв гэх мэт) үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын ажилчид, ус зөөвөрлөх том оврын машин, техник хэрэгслийг дайчлан түймрийг унтраахад оролцсон байна. Тухайлбал “Оюутолгой” компани 2017 оны 7 сард “Ланд крүзер” автомашин 2, хөдөлмөр хамгааллын хувцас 359, 30 метрийн галын шланг 8, 1 тонны багтаамжтай усны сав 200, 6 тонны эвхдэг сав 1, галын эвхдэг шат 2, хүрз 35 ширхгийг хандивласан байна. | 100 |
| 19 | 23 | **Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай**<br>2017-07-18 №208<br><br>2. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн авто замаас Өлзийт, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн 120 км хатуу хучилттай авто замыг холбох ажил гүйцэтгэх “Шинжиан шинфа” ХХК-ийн 360, Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолтын ажил гүйцэтгэх “Петрочайна дачин тамсаг монгол” ХХК-ийн 176 гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд Монгол Улсад 2017 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт зөвшөөрсүгэй. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2017 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдэгдэхийг холбогдох сайд нарт даалгасугай. | БХЗГ | Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 708 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах, мөн тус компанийн гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрлийн хугацааг 2 сараар бус он дуустал олгох асуудлыг тус тус шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичгийг ХНХЯ-д уламжлаад байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | 24 | **Өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох тухай**<br>2017-07-18 №210<br><br>1. Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийн 5.3.3-т заасныг хэрэгжүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх үйл ажиллагааг олон нийтийн хяналтын дор ил тод, чирэгдэлгүй явуулах зорилгоор өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | ТЗУГ-ХХ | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг цахим хэлбэрээр олгох ажиллагааг 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр бүх бэлтгэлийг хангасны үндсэн дээр эхлүүлсэн боловч Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн эрүүгийн цагдаагийн газрын төлөөлөл оролцсон Ажлын хэсгийн дүгнэлтээр техникийн саатал үүссэн болох нь тогтоогдсон тул уг ажиллагааг түр хойшлуулсан болно. 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгохтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох ажиллагаа цаашид хийгдэхгүй болно. | 100 |
| | 25 | **Өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох тухай**<br>2017-07-18 №210<br>2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгохтой холбогдсон журам, зааврыг баталж мөрдүүлэх, энэ талаар олон нийтэд мэдээлж сурталчлах, үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох зэрэг ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт даалгасугай. | ТЗУГ-ХХ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/160 дугаар “Үйлчилгээний хөлс тогтоох тухай” тушаалаар цахим хэлбэрээр өргөдлийн дугаарыг олгохтой холбоотой үйлчилгээний хөлсийг баталж, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны а/130 дугаар тушаалаар “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар”, “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд хөдөлгөөн хийхтэй холбоотой өргөдлийн бусад маягтын загвар”-ыг тус тус баталсан. | 100 |
| **5.ё. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 1 | 1 | **Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай**<br>**2014-05-16 №61**<br>2 Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай. | ТЗУГ-СХ | Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн ажлыг нэгтгэж тайлагнах тул яамнаас биелэлт гаргах шаардлагагүй. | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | Ажлын хэсэг байгуулах тухай“Монгол-Хятадын Экспо” арга хэмжээ<br>2016-02-12 №22<br><br>2 “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2 жил тутам уламжлал болгон зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай“Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2 жил тутам уламжлал болгон зохион байгуулах ажлын бэлтгэлийг сайтар хангаж, дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай. | ТЗУГ-ГХАХ | Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалын хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод 2015 оны 10 дугаар сард "Монгол-Хятадын анх дугаар экспо" арга хэмжээг хоёр тал хамтран зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний үеэр уул уурхайн салбартай холбоотой Монгол-Хятадын уул уурхайн салбарын уулзалт, дугуй ширээний ярилцлага, уул уурхайн салбарын үзэсгэлэн, Монгол бараа, бүтээгдэхүүний худалдаа зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, тус салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэн өргөн бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Энэ жилийн хувьд 2 дугаар экспог зохион байгуулах ажлын хүрээнд “Монгол-Хятадынэкспо 2017” арга хэмжээг зохион байгуулах зарим аргах эмжээний тухай Засгийн газрын 2017 оны 150 дугаар тогтоолыг ХХААХҮЯ-наас батлуулж, зохион байгуулалтыг ханган ажиллав. Тус яамны зүгээс 2017 оны 09 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд "Хөрөнгө оруулалт шаардлагатай томоохон төслүүд" болон "Монгол, Хятад, Оросын ашигт малтмалын чуулга уулзалт" сэдэвт салбар хуралдаануудыг Үндэсний хөгжлийн газартай хамтран амжилттай зохион байгуулсан болно. | 100 |
| 3 | 3 | Ажлын хэсэг байгуулах тухай “Арева Майнс” ХХК<br>2017-03-29 №58<br><br>2 “Мон Атом” ХХК болон “Арева Монгол” ХХК-ийн хооронд 2013 онд байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд хууль зүйн дүгнэлт гаргаж, уг компанийн хувьцааг төр эзэмшихтэй холбогдсон асуудлаар санал боловсруулж 2017 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | БХЗГ<br>ТЗУГ-ХХ | Ажлын хэсэг холбогдох материал, баримт бичгүүдтэй танилцсаны үндсэн дээр "Арева Монгол" ХХК-аас нэмэлт санхүүжилтийн үүрэг хүлээхгүй байх асуудлаар Батламж захидал авах нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрсэн бөгөөд уг дүгнэлтийг Цөмийн энергийн комисс, Эрдэнэс Монгол ХХК болон Ерөнхий сайдад танилцуулсан. Хууль зүйн дүгнэлтийн дагуу гаргуулан авах шаардлагатай байсан Батламж захидлыг хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийсний үндсэн дээр "Арева Монгол" ХХК-аас 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр гаргуулан авсан бөгөөд уг Батламж бичгийн 2 дахь хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хугацаанд болон санхүүжилтийн дараа "Мон-Атом" ХХК нь "Арева Майнс" ХХК-д шаардсан хөрөнгө нийлүүлэх тухай аливаа үүрэг хүлээхгүй байдлаар оруулсан. Уг батламж бичгийн гаргуулж авснаар цаашид хөрөнгө оруулагчийн зүгээс Монголын талд санхүүжилтийн аливаа үүрэг хүлээлгэх нөхцөлийг бууруулж, Монголын талын үр өгөөжийг нэмэгдүүлэх давуу талтай юм. | 100 |

| 5.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | **2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>2012-04-18<br>10.1 Бичил уурхайн үйл ажиллагааны хамрах нутаг дэвсгэрийн хүрээ, бичил уурхайчдын тоог харгалзан сумын батлагдсан орон тоо, төсөвт нь багтаан Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд бичил уурхайн асуудлыг тодорхой ажилтанд хариуцуулан ажиллуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд Д.Хаян хярваа, аймаг, сумдын Засаг дарга нарт даалгав | БХЗГ | Тус яам УУХҮС-ын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай жил бүр байгуулдаг хамтран ажиллах гэрээнд уг заалтыг тусган, биелэлтийг ханган ажиллаж байна. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| 2 | 2 | **2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>2016-04-11<br><br>XX.4. “Гурвансайхан” ХХК-иас Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох хүсэлт гаргасан талаар Эрчим хүчний сайд Д.Зоригт Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Дундговь аймгийн | БХЗГ | “Гурвансайхан” ХХК-иас Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг Дундговь аймгийн Баянжаргалан, Өлзийт сумдын нутагт орших 1017X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хайрхан, Дорноговь аймгийн Даланжаргалан, Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил сумдын нутагт орших 1021X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хараат, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших 1018X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Гурвансайхан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Баянжаргалан, Өлзийт сумдын нутагт орших 1017X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хайрхан, Дорноговь аймгийн Даланжаргалан, Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил сумдын нутагт орших 1021X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Хараат, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших 1018X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Гурвансайхан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян сумдын нутагт орших 1068X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Өлзийт зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурвансайхан” ХХК-д олгох асуудлыг зарчмын хувьд дэмжиж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгав. | | сумдын нутагт орших 1068X дугаарын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Өлзийт зэрэг цацраг идэвхт ашигт малтмалын орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурвансайхан” ХХК-д 2016 онд олгосон. **ХАСАХ САНАЛТАЙ** | |
| 3 | 3 | 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2017-04-26 №: 2017_18<br><br>XIY. Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2017 оны 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас баталсан хуваарийн дагуу зохион байгуулж, яамныхаа үйл ажиллагаа, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэл өгөхийг Засгийг газрын гишүүдэд даалгав. | ТЗУГ | Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Төрийн нарийн бичгийн даргын А/77 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан 2017 оны 06 дугаар сарын 14-нөөс 15-ны өдрүүдэд Нийслэлийн Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгууллаа.<br>Тус “Нээлттэй хаалганы өдөрлөг”–т хамтран ажиллахаар 25 байгууллага 28 асарт хоёр өдрийн турш олон нийтэд зориулсан танилцуулга, сурталчилгаа хийж оролцсон. Өдөрлөгийн үйл ажиллагааны нэг гол хэсэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр салбарын үйл ажиллагааг сурталчлах ажил байсан бөгөөд энэ ажлын хүрээнд 17 хэвлэл, мэдээллийн байгууллагыг урьж, тус бүр мэдээ, ярилцлага, сурвалжилга, фото сурвалжилга гаргасан болно. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 4 | **2016 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2016-05-31**<br>Ү.1 Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний түвшний шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах ажлын явц, үр дүнг хэлэлцээд дараах арга хэмжээг 2016 онд багтаан авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгав: Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлж, суурь болон зорилтот түвшинг салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан тодорхойлохыг Засгийн газрын гишүүдэд; | БҮХ ГАЗРУУД | Тус тэмдэглэлийн дагуу "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.4-т тусгасан Эрдэс баялгийн салбарын зорилтод уялдуулан хэрэгжүүлсэн. Хяналтаас хасуулах | 100 |
| 5 | 5 | **2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр 46 дугаар тэмдэглэл**<br>2016-09-14<br>Х. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав:<br><br>1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хөтөлбөрийн зорилтуудаас ойрын хугацаанд хэрэгжүүлэх боломжтой, санхүүгийн эх үүсвэр шаардагдахгүй, яаралтай хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан | ТЗУГ ХХ | Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 онд шинээр хэрэгжүүлэх геологи хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог УУХҮ-ийн ТНБД-ын 2017 оны А/13 дугаар тушаалаар байгуулан тендерийг 11 багцтайгаар нээлттэй зарлан 2017 онд шинээр хэрэгжүүлэх 11 багц тендерийг зарлан дүгнэж байна. Мөн уулуурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны багцад шаардлагатай нэмэлт 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар батлуулж, томоохон үйлдвэрүүдийг барих төслийг хэрэгжүүлэх нэгжүүдийг байгуулан ажлыг эхлүүлээд байна. Монгол Улсын Засгийн | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын хуралдаанд оруулах;<br><br>2. Монгол Улсын Ерөнхий сайд салбарын төлөөлөлтэй уулзах явцад гарсан саналуудыг судлан хэрэгжих боломжтой арга хэмжээг тооцоо, судалгаа гарган төлөвлөгөө боловсруулж, шуурхай хэрэгжүүлж эхлэх, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулах, улсын эдийн засаг, төсөв санхүүгийн хүндрэлтэй байгаа одоогийн нөхцөлд хэрэгжих боломжгүй саналын талаар холбогдох байгууллагад мэдэгдэн хариу өгөх; | | газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Алт-2" үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд алтны олборлолт, борлуулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг сэргээх, Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. -<br>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг журмыг шинэчлэн баталснаар бичил уурхай эрхлэгчдийг бодлогын түвшинд дэмжих замаар Монгол Улсын эдийг засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох зорилт биелэгдэнэ.<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 тоот захирамжаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулж, хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг Монгол Улсын зүгээс баримтлах гэрээ, хэлэлцээний үндсэн зарчмыг хөрөнгө оруулагч талд тавьсан болно.<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны 20 дугаар захирамжаар “Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн хөрөнгө оруулагчтай хийх Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг, 21 дүгээр захирамжаар “Гацууртын алтны үндсэн орд ашиглах гэрээ”-ний төсөл бэлтгэх, хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулсан. Хоёр ажлын хэсгийн зүгээс 2017 оны 3 болон 4 дүгээр сард Орд ашиглах гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг бэлтгэн “Сентерра гоулд Монголия” ХХК-руу хүргүүлсэн бөгөөд хөрөнгө оруулагчаас гэрээнд өгөх саналуудыг ирүүлсэнээр хэлэлцээний ажил үргэлжлэн явагдана. - Ашигт малтмал, газрын тосны салбарын хууль тогтоомжийн хийдэл, зөрчил, давхардлыг арилгах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран төсөл хэрэгжүүлсэн бөгөөд ашигт малтмал, газрын тосны салбарын багц 10 хуулиудын | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар хуулийн төслүүдийг УИХ-ын 2018 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. -“Мон Атом” ХХК болон “Арева Монгол” ХХК-ийн хооронд 2013 онд байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд хууль зүйн дүгнэлт гаргаж, олбогдох материал, баримт бичгүүдтэй танилцсаны үндсэн дээр "Арева Монгол" ХХК-аас тодорхой асуудлаар Батламж захидал авах нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрсэн бөгөөд уг Батламж захидлыг "Арева Монгол" ХХК-аас 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн бөгөөд уг Батламж бичгийн 2 дахь хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хугацаанд болон санхүүжилтийн дараа "Мон-Атом" ХХК нь "Арева Майнс" ХХК-д шаардсан хөрөнгө нийлүүлэх тухай аливаа үүрэг хүлээхгүй байдлаар оруулсан. Ийнхүү батламж бичиг гаргаж өгснөөр тус төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.<br>- Уул уурхайн тухай хуулийн төслийг боловсруулахаар ЕСБХБ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд гадаадын зөвлөх баг хуулийн төслийн эхний төслийг бэлтгэн ирүүлсэн. УУХЗЯ дээр байгуулагдсан ажлын хэсэг ирүүлсэн төсөлд санал өгөх ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны багцад шаардлагатай нэмэлт 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар батлуулж, томоохон үйлдвэрүүдийг барих төслийг хэрэгжүүлэх нэгжүүдийг байгуулан ажлыг эхлүүлээд байна. Мөн геологи хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж, зорилтот түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 2017 онд шинээр хэрэгжүүлэх 11 багц тендерийг зарлан дүгнэж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 6 | XI.4. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн өнөөгийн байдал, хүндрэлтэй асуудлын талаар Эрчим хүчний сайд П.Ганхүү Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Төв, суурин газрын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 338 дугаар тогтоолын 4,5,6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, өвлийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарт даалгав. | ТБГ БХЗГ | “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК тай холбоотойгоор “Төв, суурин газрын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 338 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авч, өвлийн бэлтгэл хانган ажилласан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| 6 | 7 | **2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>2016-09-28<br><br>XҮII.2. 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. | ТЗУГ СХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх зөвлөмжийг харьяа агентлагтаа хүргүүлж, Дотоодын худалдан авалтын тайланг ТНБД-ын 2017 оны 12 сарын 28 өдрийн 03/2751 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлж ажиллаа. | 100 |
| | 8 | XҮII.2. 5. Нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, худалдан авалт хийсэн байгууллагыг урамшуулах, худалдан авах ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. | ТЗУГ СХ | УУХҮ-ийн сайдын багцын худалдан авалтын хүрээнд аль болох дотоодын бараа худалдан авах чиглэлийг өгч, 2017 онд УУХҮЯ-наас геологи, хайгуул судалгааны ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээ, ТХН-ийн дотоодын зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулж нийт 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Мөн УУХҮЯ-наас 10.4 сая төгрөгийн, АМГТГ-аас 5.2 сая төгрөгийн бичиг хэргийн дотоод худалдан авалтыг хийсэн. | 100 |
| 7 | 9 | **2016 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл**<br>2016-10-26<br>XIII.1. 2. хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас | БҮХ ГАЗРУУД | Тус заалтад дурдсан нөхцөл байдал үүсээгүй болно. | /-/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт. | | | |
| 8 | 10 | **2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл**<br>2017-01-04<br><br>ҮII. 3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан хуваарийн дагуу Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон өөрийн эрхлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлыг 14 хоног, сар, улирал бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тогтмол мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | ТЗУГ-Хэвлэл | Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон өөрийн эрхлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлыг 14 хоног, сар, улирал бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тогтмол мэдээлэх арга хэмжээ авч ажиллах талаар даалгасны дагуу:<br>-"Засгийн газрын цаг" нэвтрүүлгийн 3 дугаар сарын дугаарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, тус яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Баатарсүх, Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбат, Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатар нар оролцон салбарын талаарх сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд танилцуулав. Уг 15 минутын нэвтрүүлгийг 12 ТВ-ийн сувгаар дамжуулсан.<br>-Канадын Торонто хотод болсон олон улсын чуулганд салбарыг төлөөлж УУХҮ-ийн сайд Ц.Дашдорж оролцсон тухай мэдээллийг Eagle, MN25, МонголHD, Bloomberg телевизүүдэд ярилцлага хэлбэрээр гаргасан.<br>-"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан тухай мэдээллийг 5 телевизээр нэвтрүүлсэн.<br>-Налайх дүүргийн нүүрс олборлогчдын асуудлыг тойрсон маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдлын тухай мэдээллийг 5 телевизээр тус бүр 2 удаа мэдээлж, 2 телевизээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>-"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн баталсан тухай мэдээг хэвлэл мэдээллийн 10 байгууллага, нэвтрүүлгийг MN25, TV 9 телевизүүдээр мэдээллэсэн. -<br>УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар үүрэгт ажилдаа томилогдсоноос хойш 12 хоногийн дараа буюу 2017 оны 11 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүгээр сарын 01-нд “Ил тод, хариуцлагатай уул уурхай” хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Тус хэвлэлийн бага хуралд УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар, Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал болон бүх газар хэлтсийн дарга нар оролцож, салбарын талаарх сүүлийн үеийн мэдээ мэдээллийг өгөн, сэтгүүлчдийн асуутад хариулав. Хэвлэлийн бага хурлын талаар MNB, Bloomberg, UBS, TV5, TV8, NTV, SBN зэрэг телевиз, news.mn, ikon.mn, assa.mn, gogo.mn, zaluu.com зэрэг мэдээллийн сайт, Өдрийн сонин, Өнөөдөр, Өглөөний сонин, Үндэсний шуудан сонингууд мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд дамжуулав. Мөн 2017 оны 12 дугаар сарын 12-нд “Ил тод, хариуцлагатай уул уурхай” хэвлэлийн бага хурал зохион байгуулж, салбарын сүүлийн үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд өглөө.<br>-УУХҮ-ийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 10-12-нд Өмнөговь аймагт, 11 дүгээр сарын 27-нд Ховд аймагт болон 11 дүгээр сарын 16, 17-ны өдөр Налайх, Сонгинохайрхан дүүрэгт ажилласан талаарх мэдээллийг MNB, Bloomberg, TV8, SBN телевиз, news.mn, zaluu.com, newsmedia.mn сайтууд, Өдрийн сонин, Өнөөдөр, Өглөөний сонин нийтлэл нэвтрүүлэг бэлтгэн гаргав.<br>-УУХҮЯ-аас 2017 оны 12 дугаар сарын 08-нд зохион байгуулсан “Тогтвортой хөгжилд уул уурхай” бодлогын зөвлөгөөн, 12 дугаар сарын 25-нд зохион байгуулсан Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойн баярын хурлыг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулж, Eagle телевизээр шууд дамжуулан MNB, TV9, MN25 зэрэг телевиз, zaluu.com, newsmedia.mn, grandnews.mn, assa.mn, info.mn сайтууд, Өдрийн сонин, Өглөөний сонин, Монголын үнэн, Үндэсний шуудан зэрэг сонингоор мэдээ мэдээлэл бэлтгэн гаргуулав.<br>-Хилийн нэвтрүүлэн чадварыг сайжруулах ажилласан талаар УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатарыг ярилцлагыг MN25 телевиз, Засгийн газрын мэдээ, Өнөөдөр сонинд гаргаж, олон нийтэд сурталчилан таниуллан ажилласан.<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайтын цаг үеийн мэдээ, мэдээлэл болон Хэлэлцүүлэг, Ил тод байдал, Бидний тухай булангуудыг цаг тухай бүрт хөтөлж, яамны сайтын мэдээллийг долоо хоногт 4-5 контентоор нэмж | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулан ажиллаж байна. Түүнчлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайтын цаг үеийн мэдээ, мэдээлэл болон Хэлэлцүүлэг, Ил тод байдал, Бидний тухай булангуудыг цаг тухай бүр хөтөлж, яамны сайтын мэдээллийг долоо хоногт 3-4 контентээр нэмж байршуулан ажиллаж байна | |
| 9 | 11 | **2017 оны 2 дугаар сарын 22-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл**<br>2017-02-22<br><br>2 Дугуй ширээний уулзалтад оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын Монголын хэсгийн дарга Ц.Дашдоржид даалгав. | ТЗУГ-ГХАХ | Монгол-Канадын дугуй ширээний ээлжит долдугаар уулзалт 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Канад Улсын нийслэл Оттава хотноо болсон бөгөөд уулзалтад Монголын талаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын Монголын хэсгийн дарга Ц.Дашдорж тэргүүтэй төлөөлөгчид, Канадын талаас Канад Улсын Гадаад хэргийн Туслах дэд Сайд Доналд Бобиаш тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.<br>Дугуй ширээний уулзалтаар талууд урьдчилан тохирсны дагуу хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагаа, худалдааны хамтын ажиллагаа, хөгжлийн хамтын ажиллагаа гэсэн үндсэн гурван сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй ярилцаж, харилцан мэдээлэл хийж, санал солилцсон бөгөөд тус уулзалтад УУХҮЯ, ГХЯ, Оттавад суугаа ЭСЯ-ны төлөөлөгчид нар оролцсон болно | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 12 | **2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр 13 дугаар тэмдэглэл**<br>2017-03-20<br>XYI.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.<br>2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов:<br>2.1. үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт бүрэн тусгаж хүрэх түвшинг бодитой тогтоох;<br>2.2. жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг оны эхнээс жигд хангаж ажиллах. | ТЗУГ-СХ | 2016 оны үндсэн чиглэлд туссан Геологи хайгуул судалгааны ажлын 9.34 тэрбум төгрөгийг Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуулиар батлуулж, шинээр 12 багц тендерийг зарлан дүгнэж, гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн ба үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлийг хянан 100% санхүүжүүлээд байна. | 100 |
| 11 | 13 | **2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 15 дугаар тэмдэглэл**<br>2017-04-04<br>III. Канад Улсын Оттава хотод 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан Монгол, Канадын Дугуй ширээний 7 дугаар уулзалтын дүнг сайшааж, угуулзалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын Монголын хэсгийн дарга Ц.Дашдоржид даалгав. | ТЗУГ<br>ГХАХ | Канад Улсын Оттава хотод 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулагдсан Монгол-Канадын Дугуй ширээний долдугаар уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ГХЯ-тай хамтран боловсруулж, УУХҮ-ийн сайд 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр баталж, биелэлтийг ханган ажиллаж байна. Уг төлөвлөгөө нь эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа, улс төрийн хамтын ажиллагаа зэрэг салбарыг хамарсан 22 ажлаас бүрдсэн. Жилийн эцсийн биелэлтийг ГХЯ-ны Америк,Ойрхи Дорнод, Африкийн газарт хүргүүлээд байна. | 100 |
| 12 | 14 | 2016 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр 24 дугаар тэмдэглэл<br>2016-04-25 №: 2016_24<br>XI. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд асуудлыг дахин судалж, хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Засгийн газарт оруулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | БХЗГ | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд асуудлыг дахин судалж, хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Засгийн газарт танилцуулсан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 15 | 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл<br>2017-01-25 №: 2017_4<br><br>II. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 5 дугаар хуралдааны дүнг хэлэлцэн сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд тус Ажлын хэсгийн Монголын хэсгийн дарга Ц.Дашдоржид даалгав. | ТЗУГ-ГХАХ | Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах” тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 5 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, 2017 оны 02 дугаар сард УУХҮ-ийн сайдаар батлуулсан. Уг төлөвлөгөөнд 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 10 зүйлийн ажлуудыг тусгасан. 2016 оны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй, хэрэгжихээр төлөвлөсөн төслүүдийн жагсаалт гаргах, төслүүдийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх гарц хайх, Германы талаас экспортын зээл шугам нээх, Орхон, Сэлэнгэ, Булган аймаг ХБНГУ-ын зарим мужтай шууд харилцаа тогтоож, хамтран ажиллах, Уул уурхай, ашигт малтмалын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, Монгол, Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн дээд сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд хамтран ажиллах зэрэг хоёр орны ашигт малтмал, эдийн засаг, боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн ажлууд тусгагдсан байна. Төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. ХБНГУ-д сонгууль болж байгаагаас шалтгаалан сонгуулийн дараа Засгийн газраа байгуулснаар холбогдох ажлуудыг эрчимжүүлнэ хэмээн Гадаад яаманд мэдэгдсэн байна. | 100 |
| 14 | 16 | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2017-05-17 №: 2017_22<br><br>XIY.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эхлүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолт, ашиглалт явуулахдаа агаар мандал болон гол мөрний усыг бохирдуулах, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг байгаль орчинд хохирол учруулж байгаа тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт үүрэг болгов. | БХЗГ | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/135 тоот тушаалаар Архангай аймгийн Цэнхэр суманд ажиллаж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ хэрэгжүүлж буй байдалтай танилцах, шаардлагатай арга хэмжээ авч, газар дээр нь холбогдох талуудтай ажиллах, санал, дүгнэлт гаргаж арга хэмжээ авч ажиллсан. Үүний үр дүнд тус суманд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн олборлолтын үйл ажиллагааг түр түдгэлзүүлсэн. Талбай дээр 3 том тунаах нуур далан барьж байгуулсан. Мөн хууль бусаар алт олборлолт багасаж Орхон гол руу бохир ус орохгүй болсон. 2017 онд дахин Орхон голыг бохирдуулсан санал гомдол гараагүй болно. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 17 | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2017-05-17 №: 2017_22<br><br>XIY.2. Бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжтой талбайн судалгааг гаргаж аймаг, сумдын Засаг даргатай тохиролцсоны үндсэн дээр бичил уурхайн ашиглалтын талбайг тогтоох, энэ талаар үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийг бүртгэлжүүлэх, зохион байгуулалтад оруулах, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдсон цогц арга хэмжээ авах чиглэлээр Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах талаар арга хэмжээ авч Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгав. | БХЗГ | Журмын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн батлуулсан. **ХАСАХ САНАЛТАЙ** | 100 |
| | 18 | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2017-05-17 №: 2017_22<br><br>XIY.2. 1. Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган болон Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэх үед сайд нар тогтмол оролцож, хариуцсан асуудлаараа Улсын Их Хурлын гишүүдэд холбогдох тайлбар, мэдээлэл өгч байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | ТЗУГ-ХХ | 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 2018 оны Төсвийн тухай хуультай дагалдан батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурал болон байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд яамны төлөөлөл тухай бүр оролцож, холбогдох тайлбар, мэдээллийг өгч ажилласан. Бусад санаачлан боловсруулж буй хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхэд мөн энэ зарчмаар ажиллах болно. /Биелэлт 100%/ | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 19 | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2017-05-17 №: 2017_22<br><br>XIY.2. 4. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төрөөс олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасгах, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах арга хэмжээний хүрээнд тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар ойрын хугацаанд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлэг хийж саналыг нь авч, холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, холбогдох сайд нарт даалгав. | ТЗУГ-ХХ | Тусгай зөвшөөрөл олголтыг нээлттэй, ил тод, хурдан шуурхай, олон нийтийн хяналт дор явагдах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулсан. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яам болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага нартай хамтран уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох чиглэлээр Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглах тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг гүйцэтгээд байна. Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хамтарсан А/298-А/240 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 оны 02 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. /Биелэлт 100%/ | 100 |
| | 20 | 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2017-05-17 №: 2017_22<br><br>XIY.3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахимаар хүлээн авч, бүртгэх үйл ажиллагаатай холбогдсон маш олон гомдол гарч байгаатай холбогдуулан уг асуудлыг нэг мөр цэгцлэн нээлттэй, ил тод, чирэгдэлгүй, шударга явуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогтод, хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгав. | ТЗУГ-ХХ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/160 дугаар “Үйлчилгээний хөлс тогтоох тухай” тушаалаар цахим хэлбэрээр өргөдлийн дугаарыг олгохтой холбоотой үйлчилгээний хөлсийг баталж, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны а/130 дугаар тушаалаар “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар”, “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд хөдөлгөөн хийхтэй холбоотой өргөдлийн бусад маягтын загвар”-ыг тус тус баталсан. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг цахим хэлбэрээр олгох ажиллагааг 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр бүх бэлтгэлийг хангасны үндсэн дээр эхлүүлсэн болович Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн эрүүгийн цагдаагийн газрын төлөөлөл оролцсон Ажлын хэсгийн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнэлтээр техникийн саатал үүссэн болох нь тогтоогдсон тул уг ажиллагааг түр хойшлуулсан болно. 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын зарчмаар олгох болсонтой холбогдуулан цаашид хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахимаар хүлээн авч, бүртгэх үйл ажиллагаа явагдахгүй болно. /Биелэлт 100%/ | |
| 15 | 21 | 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 23 дугаар тэмдэглэл<br>2017-05-24 №: 2017_23<br>X.2. Цаашид “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүр Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр шийдвэрлэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгав. | ТЗУГ-ХХ | Уг тэмдэглэлийн дагуу УУХҮЯ-ны Сайдын 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/129 дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох журмыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 3768 дугаарт бүртгүүлсэн. /Биелэлт 100%/ | 100 |
| 16 | 22 | **2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл**<br>2017-07-18<br>ҮII.2. Холбогдох төрийн байгууллагын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан газар дээр нь шалгаж, гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг хариуцлага тооцох арга хэмжээ авч, дүнг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин аялал, жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат нарт даалгав. | БХЗГ | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны “Гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллах” тэмдэглэлийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэстэй хамтран Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутагт усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлүүдэд “Төрийн хяналт шалгалтын тухай” болон холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар 30 нөхөрлөл, хууль бус бичил уурхайчдын үйл ажиллагааг улсын байцаагчийн 10 актаар зогсоон "Хааны харгуй" ХХК, "Толгойтын гол" ХХК, "Бүүргэнэт" ХХК-уудад хугацаатай албан шаардлага өгч, хууль бус бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байсан 2 иргэн, 2 нөхөрлөлийн нийт 5 экскаваторын компьютерыг газар дээр нь хурааж, Хүдэр | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | суман дахь хууль бус ашигт малтмал олборлох зорилгоор 50 гаруй иргэдийг албадан буулгах, талбай чөлөөлөх арга хэмжээг авч ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газруудад хяналт шалгалтын талаарх мэдээллийг хүргүүлсэн. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын сайдын 2017 оны А/135 тушаалаар ажлын хэсэг байгуулан, 2017 оны 5 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад Байгаль орчин аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, тус аймгийн мэргэжлийн хяналтын газар,Байгаль орчны газар, Орхон гол, Чулуутын голын сав газрын захиргаа, Өвархангай аймгийн мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газруудтай хамтарсан шалгалт хийж, санал, дүгнэлтийг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. | |
| | 23 | **2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл**<br>2017-07-18<br><br>ҮII.3. Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нутаг дэвсгэрт хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад ашигт малтмалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл арга хэмжээ авах талаар Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж, дүнг танилцуулахыг Байгаль орчин аялал, жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт даалгав. | БХЗГ | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 17/01 тоот дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 25-ны өддрийн 429 дүгээр шийдвэрээр Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт орших Гутайн даваа нэртэй 341.79 гектар талбай бүхий "Ю энд Би" ХХК-ийн эзэмшлийн MV-002810 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | 24 | **2017 оны 8 дугаар сарын 9-ний өдөр 35 дугээр тэмдэглэл**<br>2017-08-09<br><br>XX.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2017 оны хагас жилийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажил үүргээ хангалтгүй биелүүлж, 2017 оны хагас жилийн үнэлгээний дүнгээр хангалтгүй гэж дүгнэгдсэн Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт хариуцлага тооцохыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад; 2. Яамныхаа хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг нэгтгэн ирүүлэх ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн яамны холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатарт; 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах ажлыг хангалтгүй биелүүлж, 2017 оны хагас жилийн үнэлгээний дүнгээр хангалтгүй гэж дүгнэгдсэн Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганболд, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Соёлчхүү, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Баянмөнх нарт хариуцлага тооцож ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт; 4. Улсын Их Хурал болон Байнгын | ХШҮДАГ | 2017 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 135 шийдвэрийн 189 заалтыг салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэж ангилан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт ерөнхий дүнгээр 83.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн ба тайланг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т 2017.06.30-ны өдрийн 1/1549 тоотоор хүргүүлж, мөн өдөр ЗГХЭГ-ын www.unelgee.gov.mn талбарт байршуулсан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нь даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр тайлагнах, “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” /www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт; 5. 2017 оны хагас жилийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа шийдвэрийг заалт тус бүрээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт. | | | |
| 18 | 25 | **2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дугээр тэмдэглэл**<br>2017-08-17<br>ХYI.3. Гол мөрнийг бохирдуулж, байгаль орчинд хохирол учруулан ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн дүнгийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний болон цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хамтран батлан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав. | БХЗГ | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны “Гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллах” тэмдэглэлийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэстэй хамтран Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутагт усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлүүдэд “Төрийн хяналт шалгалтын тухай” болон холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газруудад хяналт шалгалтын талаарх мэдээллийг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 26 | **2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл**<br>2017-08-17<br><br>ХYI.3. 2. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангуулах, эвдэрсэн газрын тооллого хийх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | БХЗГ | 1. Хууль бус ашигт малтмалын олборлолтын талаар Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн 2016 онд гаргасан судалгаагаар нийт 17 аймгийн 44 сумын нутаг, 140 нэр бүхий байршилтай газарт 6,524 иргэн хууль бус ашигт малтмалын олборлолт явуулахдаа 321 экскаватор, 169 ширхэг усан буу, скрупер, 379 том оврын машин ашигласан байна. 2. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2016 онд гаргасан Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайланд ашигт малтмал олборлож буй 5998 (алт 4865, нүүрс 135, жонш 685, гянтболд 157, бусад 156) иргэд 18 аймгийн 97 сум, нийслэлийн 1 дүүргийн 113 талбайн 332 байршилд үйл ажиллагаа явуулж байгаа талаар тус тус дурдсан.3. 9 аймгийн 11 сумаас ирсэн 2016 оны бичил уурхайн үйл ажиллагааны мэдээ, тайланг мэдээллийн санд нэгтгэсэн. 4. 9 аймгийн 21 сумдад 2017 онд албан томилолтоор ажиллах үеэр аймаг, сумдын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, бичил уурхайн эвдэрсэн газрын мэдээг авч нэгтгэсэн. Дээр дурдсан 4 эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэн эдвэрсэн газрын жагсаалтыг гаргасан. | 100 |
| | 27 | **2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл**<br>2017-08-17<br><br>ХYI.3. 4. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлон байгаль орчинд ихээхэн хэмжээний хохирол учруулсан “Рич Мөнх” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах, байгаль орчинд учруулсан хохирлыг бүрэн тооцож нөхөн төлүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгов. | БХЗГ | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны “Гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллах” тэмдэглэлийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэстэй хамтран Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутагт усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлүүдэд “Төрийн хяналт шалгалтын тухай” болон холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газруудад хяналт шалгалтын | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | талаарх мэдээллийг хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт ирүүлээгүй тул “Рич Мөнх” ХХК-ийн MV-020530 тоот тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байна. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг зөрчсөн аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг Улсын мөрдөн байцаах газрын Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс болон Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн шалгаж байна. Үүнд “Рич мөнх” ХХК-ийн MV-020530 тоот тусгай зөвшөөрөл орсон байна. | |
| 19 | 28 | **2017 оны 8 дугаар сарын 23-ны өдөр 37 дүгээр тэмдэглэл**<br>2017-08-23<br><br>XIY.1. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 2017 оны эхний хагас жилд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | ТЗУГ | Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг хуулийн хугацаанд өгч ажилласан. 2017 онд  нийт 51 хүсэлт, санал ирсэнд, геологи, уул уурхайтай холбогдсон асуудлуудад хариултыг бодлогын газруудаас бэлтгүүлэн авч, бүгдэд нь тухай бүр хариуг хүргүүлж ажилласан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | 29 | **2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл**<br>2017-09-13<br>XXXII.2. 1 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. | ТЗУГ-СХ | 2017 онд УУХҮЯ-наас геологи, хайгуул судалгааны ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээ, ТХН-ийн дотоодын зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулж нийт 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлыг эхлүүлээд байна. | 100 |
| | 30 | **2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл**<br>2017-09-13<br>XXXII.2. 2 Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | ТЗУГ-СХ | УУХҮ-ийн сайдын 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг 3 дугаар улирлын байдлаар гарган УУХҮЯамны 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 03/2261 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2017 оны 4 дүгээр улирлын тайланг гаргаж байна. | 100 |
| 21 | 31 | **2017 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 43 дугаар тэмдэглэл**<br>2017-10-03<br>X.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт даалгав: 1.1. биелэлт хангалтгүй байгаа 70 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2017 оны жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй хамт тайлагнах. | ХШҮДАГ | Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд УУХҮС-ын эрхлэх асуудлаар тусгагдсан 28 арга хэмжээг хяналтанд авч, хагас жилийн биелэлт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасан хугацаанд ХЭГ-т хүргүүлсэн. Үнэлгээний дүнг unelgee.gov.mn сайтад байршуулж баталгаажуулсан. Удаашралтай 2 арга хэмжээг эрчимжүүлж ажиллах талаар холбогдох нэгжүүдэд үүрэг өгөгдсөн. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 32 | **2017 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 43 дугаар тэмдэглэл**<br>2017-10-03<br><br>Х.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд 2017 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилт удаашралтай, хөрөнгө шаардахгүй 130 зорилт, арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж жилийн эцсээр зорилтот түвшинд хүргэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов. | ХШҮДАГ | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд УУХҮС-ын эрхлэх асуудлаар тусгагдсан 105 арга хэмжээг хяналтанд авч, хагас жилийн биелэлт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасан хугацаанд ХЭГ-т хүргүүлсэн. Үнэлгээний дүнг unelgee.gov.mn сайтад байршуулж баталгаажуулсан. Удаашралтай 6 арга хэмжээг эрчимжүүлж ажиллах талаар холбогдох нэгжүүдэд үүрэг өгөгдсөн. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | 33 | **2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл**<br>2017-10-20<br>I. Салбаруудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан байдал, явцын талаар хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав: 1.1. 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, явцыг эрчимжүүлэх талаар Засгийн газраас гарсан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангах арга хэмжээ авч үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байх; 1.2. өвс, тэжээл, буудайн нөөц бүрдүүлэх, махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, төв суурин газарт махны нөөц бүрдүүлэх, байгалийн аюулт үзэгдэл (ой, хээрийн түймэр, мал, амьтны гоц халдварт өвчин)-ийн улмаас учирсан хохирол болон хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг төсвийн тодотгол батлагдсан даруйд хугацаанд нь санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг одооноос хангах; 1.3. Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлын хүрээнд хамаарах Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллага хэвийн ажиллаж, иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэн өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой байгууллага, иргэдийн хүсэлт, гомдолд шуурхай хариу өгч барагдуулж байх; 1.4. бүх шатны сургууль, дотуур байр, цэцэрлэг, эмнэлэг, орон сууц, үйлчилгээний байгууллагын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулж, хүүхэд, оюутан тав тухтай амьдрах, хичээллэх, иргэд дулаан, тохилог амьдрах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч, энэ талаар гарсан гомдлыг яаралтай барагдуулж байх; 1.5. өвөлжилтийн бэлтгэлийн дутууг хангах талаар хөрөнгө зардал шаардагдахгүй ажлыг тухайн байгууллага, газар, нэгжийн удирдлагад хариуцуулан зохион байгуулж, биелэлтийг нь тухай бүр дүгнэн эрхэлсэн ажилдаа хайхрамжгүй хандсан албан тушаалтантай хариуцлага тооцож ажиллах. | БХЗГ | "Багануур" ХК," "Шивээ-Овоо" ХК-уудад авахад бэлэн нүүрсний нөөцийг хэвийн хэмжээнд байлгах талаар үүрэг өгч, мэдээг тогтмол авч ажиллаж байна. “Багануур” ХК 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар сард 2.97 сая тн нүүрс олборлохоос 3.06 сая тн нүүрс олборлож, төлөвлөгөөний биелэлт 100.2 хувьтай байна. Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 67 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 99 хувьтай байна. Тус компани Дулааны 4-р цахилгаан станц /ДЦС-4/, ДЦС-3, ДЦС-2, Дарханы ДЦС, Багануурын ДС, Амгалангийн ДС-ын эрчим хүчний нүүрсний хэрэглээг хангаж байна. Эдгээр Дулаан болон цахилгааны станцуудын гаднах талбай дахь нүүрсний нөөцийг дурьдвал: /ДЦС-4/ – 19 хоног, /ДЦС-3/ – 16 хоног, /ДЦС-2/ – 21 хоног, /ДДЦС/ – 22 хоногийн тус тус нөөцтэй байна. “Шивээ-Овоо” ХК 2017 оны эхний 10 сард 1.59 сая тн нүүрс олборлохоос 1.57 сая тн нүүрс нүүрс олборлон 1.5 сая тн нүүрс борлуулсан байна. Тус компани 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 42 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 73 хувьтай байна. Тус компани ДЦС-4, Налайхын ДС, Бор-Өндөрийн УБҮ, УБТЗ, Дорноговь ДС, Говьсүмбэр ДС болон бусад хэрэглэгчдийг эрчим хүчний нүүрсээр хангаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | 34 | 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр 46 дугаар тэмдэглэл<br>2017-11-01 №: 2017_46<br><br>III. Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулан Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын хуралдааны журам”-ыг баримталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хянуулсны үндсэн дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. | ТЗУГ-ХХ | 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш Засгийн газрын хуралдаанаар "Нүүрс тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай", "Налайхын нүүрсний уурхайн зарим нутаг дэвсгэрийг улсын тусгай хэрэгцээнд авах тухай", "Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны тухай" зэрэг асуудлуудыг холбогдох газартай хамтран хэлэлцүүлсэн бөгөөд ийнхүү хэлэлцүүлэхдээ Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын хуралдааны журам"-д заасны дагуу холбогдох яамдуудаас санал авч, тооцоо судалгаа хийсний үндсэн дээр танилцуулсан. /Биелэлт 100%/ | 100 |
| **5.з. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 1 | 1 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай<br>2017-10-26 №: 01<br><br>1. Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна: 1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах; | ТЗУГ | Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврыг 10 дугаар сарын 30-ны өдрийн яамны удирдлагын шуурхай хуралдаан дээр танилцуулж, яамны нийт албан хаагчдад танилцуулж, мөрдөж ажиллах талаар Төрийн нарийн бичгийн дарга үүрэг өгсөн.<br>11 дүгээр сарын 01-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Яамны нийт албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллахыг сануулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй танилцуулан баталгаажуулж, нийтийн албан хаагчийн хувийн хэргийн материалд хавсаргасан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>1.2 1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;<br>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01 | ТЗУГ | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Нийт ажиллагсдаас Авлигтай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд ХАСХОМ болон бусад холбогдох мэдээллийг гаргуулан хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| | 3 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>1.3 1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах; | ТЗУГ | “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг хуулийн хугацаанд өгч ажиллаж байна. 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар яамны нэр дээр “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д нийт 51 санал, хүсэлт ирсэн бөгөөд 49-д нь хариу өгч, 12 дугаар сарын 12-нд ирсэн 2 асуудалд Геологийн бодлогын газар хариу албан бичиг бэлтгэж байна. | 70 |
| | 4 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>1.4. 1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих; | ТЗУГ | Төрийн албаны үр ашгийг сайжруулах, ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах ажлын хүрээнд 12 дугаар сарын эхний 7 хоногт 3 удаа цагийн бүртгэлийг хоцрогдсон албан хаагч тус бүрээр гаргаж, шалтгааныг тодруулж, хүндэтгэх шалтгаангүй ажлаас хоцорсон албан хаагчдад сануулах арга хэмжээ авсан. Мөн Монголын хүний нөөцийн институттай хамтран "Цагийн менежмент" сэдэвт сургалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| | 5 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>1.5. 1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх. | ТЗУГ | Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллаж байна. 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар хууль зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан явдал илрээгүй байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 6 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах; | ТЗУГ | Яамны ажиллагсдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг холбогдох бүтцийн нэгжийн дарга нараар дүгнүүлж, дараагийн шатны дарга /Төсвийн шууд захирагч/-д танилцуулж баталгаажуулсан. | 100 |
| | 7 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br><br>2.2 2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах; | ТЗУГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны зарлал, явцын мэдээ, үр дүнг яамны бодлогын газрууд /ГБГ/ Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлж ил тод байдлыг ханган ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгох үүднээс 2017 оны 11 дүгээр сарын 10-нд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгодог байсныг өөрчлөн сонгон шалгаруулалтаар олгохоор болсон бөгөөд энэхүү хуулийн хэрэгжилтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах болно. | 100 |
| | 8 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br><br>2.3 2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх; | ТЗУГ | Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх зарчмыг өдөр дутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, яамны үйл ажиллагааг дотоодод болон гадаадад сурталчлах, танилцуулах чиглэлээр байгууллагын вэб хуудсанд цаг үеийн мэдээллийг тухай бүр оруулж, “Ил тод уул уурхай” сэдэвт хэвлэлийн бага хурлыг сар бүрийн эхний долоо хоногийн даваа гараг бүр яаман дээр зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| | 9 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>2.4 2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага | ТЗУГ | Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтан байхгүй болно. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх; | | | |
| | 10 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>2.5 2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах. | ТЗУГ | Яамны ажиллагсдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг холбогдох бүтцийн нэгжийн дарга нараар дүгнүүлж, дараагийн шатны дарга /Төсвийн шууд захирагч/-д танилцуулж баталгаажуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбон ажиллаж байна. | 70 |
| | 11 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01<br>5. Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна. | ТЗУГ | Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг гарган Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 03/2622 тоот албан бичгээр 12 дугаар сарын 11-ны өдөр хүргүүлсэн болно. | 100 |

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**2018 он**